

АГУУЛГА

НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН	2-11
<p>Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт, түүний хэрэгжилт</p>	
ХОЁР. ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН	12-16
ГУРАВ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	17-58
<p>Дүрмээр хүлээсэн үндсэн чиг үүргийн хүрээнд хийсэн ажлын хүрээнд:</p>	
<p>3.1 Захиргааны дотоод ажлын чиглэлээр</p>	
<p>3.2 НЗЗ-ны байруудын инженерийн байгууламжийн ашиглалт, ус дулаан цахилгааны хэвийн, найдвартай ажиллагааг ханган ажиллах чиглэлээр</p>	
<p>3.3 Цэвэрлэгээ үйлчилгээ, эрүүл ахуйд нийцсэн зоогийн үйлчилгээний талаар</p>	
ДӨРӨВ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ	57-60
ТАВ. БУСАД ЦАГ ҮЕИЙН АЖЛЫН ХЭРЭГЖИЛТ	62-67
ЗУРГАА. ДҮГНЭЛТ	67-68

**НИЙСЛЭЛИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2020 оны 01 дүгээр сарын 03

Улаанбаатар хот

Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газар нь Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2019 оныг “Иргэдийн оролцоотой-Хөгжлийн жил” болгон зарласны хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан 2019 оныг “Байгууллагын хөгжил-Үйлчилгээний чанар”-ын жил болгон зарлаж Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг дарга түүний Тамгын газар, Захирагчийн ажлын алба, Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагуудад чанар стандартад нийцсэн нийтлэг үйлчилгээг үзүүлж, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын төрийн албан хаагчдын ажиллах тав тухтай орчин, нөхцөлийг бүрдүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллалаа.

Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газар нь 2019 оны жилийн эцсийн байдлаар удирдах төрийн захиргааны албан хаагч 1, төрийн үйлчилгээний нийт 289 ажилтан, албан хаагчийн орон тоотойгоор нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, түүний төрийн албан хаагчдад үзүүлэх төрийн үйлчилгээний чанар стандартад нийцсэн нийтлэг үйлчилгээг хэрэгжүүлэн ажиллаж байна. Тус газар нь Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/635 дугаар захирамжийн дагуу Захиргаа, санхүүгийн хэлтэс, Үйлчилгээний алба, Байр ашиглалтын алба гэсэн бүтэцтэйгээр Нийслэлийн Засаг захиргааны 1, 2, 3, 4, 5 дугаар байрууд болон Монгол Улсын Засгийн газрын 2016 оны “Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 141 дүгээр тогтоол, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2014 оны “Ухаалаг Улаанбаатар хөтөлбөр батлах тухай”, 2015 оны “Төрийн үйлчилгээний нэгдсэн төв байгуулах тухай” 185 дугаар тогтоолын дагуу байгуулагдсан Нийслэлийн Үйлчилгээний Нэгдсэн төв Дүнжингарав, Мишээл, Драгон, Оргил салбар, Баянхошуу дэд төвийн цэвэрлэгээ, үйлчилгээ, байр ашиглалтыг хариуцан, мөн Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагуудын хэмжээнд төрийн үйлчилгээг хэвийн жигд тасралтгүй явуулахад шаардлагатай хөрөнгө, санхүүг төлөвлөн зарцуулах, хөрөнгө материалын ашиглалт, хадгалалтад хяналт тавих, ажил үйлчилгээний төсвийг хянах, хянагдаж батлагдсан төсөв хөрөнгийн төлбөр тооцооны гүйлгээг цаг хугацаанд нь хийж гүйцэтгэх санхүүгийн үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна. Мөн Хангарди ордны зоогийн газар, НЗДТГазар, Улаанбаатар чуулгын байруудад байрлах цайны газрууд нь төрийн албан хаагчдад зориулсан өдөр тутмын зоог болон төрийн томоохон хүлээн авалт, хээрийн зоогийн үйлчилгээг технологийн дагуу үзүүлж байна.

Нийслэлийн Засаг даргын 2018 оны Б/10 дугаар захирамжаар Х.Эрдэнэбилэг нь Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилогдон, Төсвийн Ерөнхийлөн захирагч, Төсвийн шууд захирагчтай 2019 оны 02 дугаар сарын 05-ны өдөр үр дүнгийн гэрээг байгуулж, хамтран ажиллахаар гэрээнд гарын үсэг зурсан.

НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газар нь Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт нийцүүлэн Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагууд, ажилтан, албан хаагчдад нийтлэг үйлчилгээний нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

1. Эдийн засгийн өсөлт-өрх бүрт**1.4. Аялал жуулчлалын төв болно.**

1.4.5 Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.4.5 “Аялал жуулчлалыг нэмэгдүүлэх зорилгоор Улаанбаатар хотод соёл урлаг, спорт, олон нийтийн арга хэмжээг тогтмол зохион байгуулах” ажлын хүрээнд:

Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хүрээнд зохиогдож буй дотоод, гадаад олон нийтийн арга хэмжээнд идэвхтэй оролцож, зохион байгуулагдаж буй арга хэмжээний үйлчилгээний ажлыг мэргэжлийн түвшинд гүйцэтгэн ажилласан. Үүнд:

- 2019 оны 01 дүгээр сарын 25, 29-ний өдрүүдэд болсон НИТХ болон НЗДТГ-ын ахмадуудад хүндэтгэл үзүүлэх хүлээн авалтын арга хэмжээг 120;
- 2019 оны 03 дугаар сарын 23-ны өдөр Монгол улсад суугаа гадаадын элчин сайдын яамдын спортын нөхөрсөг тэмцээний хүлээн авалтыг 160;
- 2019 оны 05 дугаар сарын 18-ны өдөр “Улаанбаатар марафон 2019” олон улсын гүйлтийн тэмцээнд оролцсон зочид, төлөөлөгчид, тамирчдад цай завсарлагааны үйлчилгээг 120;
- 2019 оны 06 дугаар сарын 18-20-ны өдрүүдэд Архивын газраас зохион байгуулагдсан сургалтад хамрагдсан оролцогсдод цайны завсарлагааны үйлчилгээг 1500;
- 2019 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн Монгол Улсын Ерөнхий сайдын Нийслэлийн үйл ажиллагаатай танилцах айлчлалын үеэр зоогийн үйлчилгээг 30;
- Үндэсний их баяр наадам Ардын хувьсгалын 98 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд Хүй 7 худаг, Төв цэнгэлдэх хүрээлэн, уяачдын наадмын төв асарт 07 дугаар сарын 11-13-ны өдрүүдэд хүндэтгэлийн хүлээн авалтыг 300 гаруй;
- Нийслэл хот үүсэн байгуулагдсаны түүхт 380 жилийн ойг тохиолдуулан Өвөрхангай аймгийн Бүрд сумын нутагт байрлах нийслэлийн анхны шавыг тавьсан гэрэлт хөшөөнд хүндэтгэл үзүүлэх арга хэмжээний үеэр Нийслэлийн удирдлагууд болон бусад зочид төлөөлөгчдөд хээрийн үйлчилгээг 200 гаруй;
- Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч С.Амарсайханы санаачилгаар 2019 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр зохион байгуулагдсан “Нэг хот-Нэг стандарт” нийслэлийн анхдугаар зөвлөгөөний үеэр НИТХ-ын дарга Р.Дагва, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч С.Амарсайхан, Нийслэлийн Засаг даргын Хөгжлийн бодлогын асуудал хариуцсан орлогч Ж.Батбаясгалан болон нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын удирдах албан тушаалтнууд, дүүрэг, хороодын Засаг дарга, хэсгийн ахлагч нарт өглөөний цайны үйлчилгээг 2100;
- Нийслэлийн Засаг даргын Хүний хөгжил, нийгмийн бодлогын асуудал хариуцсан орлогч Нийслэл дэх жендэрийн салбар хорооны дарга Ш.Анхмаагийн санаачилгаар 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдөр зохион

байгуулагдсан “Жендэр ба хөгжил” нийслэлийн анхдугаар чуулганаар Чуулганд УИХ-ын гишүүн Б.Саранчимэг, нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч С.Амарсайхан, нийслэлийн Хүний хөгжил, нийгмийн бодлогын асуудал хариуцсан орлогч, нийслэл дэх Жендэрийн салбар хорооны дарга Ш.Анхмаа тэргүүтэй холбогдох албан тушаалтнууд, дүүрэг, хороодын төрийн байгууллагын удирдлага, сургууль, цэцэрлэгийн захиралууд, аж ахуйн нэгжийн төлөөлөл, төрийн бус байгууллага болон олон улсын байгууллагын төлөөллүүдэд өглөөний цайны үйлчилгээг 1000 гаруй зочид, төлөөлөгчдөд тус тус амжилттай зохион байгуулан ажилласан.

5. ЗАСАГЛАЛ

5.1 Оновчтой бүтэц, уялдаатай үйлчилгээ, хариуцлагатай албан хаагч

5.1.2 Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.1.2 дахь заалт, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 5-5 дахь хэсэг “Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтээр”-ээр үнэлэхэд хүний нөөцийн бүртгэл, төлөвлөлтийн /ERP/ системийн мэдээллийн санг ашиглаж, хүний нөөцийн чадавхийг хөгжүүлнэ.”

Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын захиргааны нийт албан хаагчид Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын системийг /www.erp.ulaanbaatar.mn/ мэдээлэл солилцох, албан бичиг хүлээн авах, илгээх, шийдвэрлэх, шийдвэрлэлтийн мэдээг байршуулах, ажлын цаг ашиглалтад бүртгэлээр хяналт тавих, нэгдсэн удирдлагаар хангах, хүний нөөцийн бүртгэлийг дэлгэрэнгүй байдлаар хөтлөх зэрэг шаардлагатай арга хэлбэрүүдээр албан хэрэгцээнд бүрэн ашиглаж хэвшээд байгаа бөгөөд байгууллагын ажилтан, албан хаагчдын цагийн бүртгэлийг бүртгэх хурууны хээ мэдрэгч төхөөрөмжийг 2019 оны 02 дугаар сараас эхлэн www.erp.ulaanbaatar.mn системд холбох ажлыг амжилттай эхлүүлсэн ба 2019 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар НЗЗ-ны 5-н байр, НҮНТ-ийн 4 салбар системд бүрэн холбогдож ажилтан, албан хаагчдын ажлын цаг ашиглалтад хяналт тавих, цаг ашиглалттай холбоотой тайлан мэдээг гаргах зэргээр албан хэрэгцээнд бүрэн хэрэгжүүлэн ажиллаж байна.

Санал асуулга, судалгаа явуулахад цаасан хэрэглээг багасгах, цаг хугацааг хэмнэх зорилгоор ERP систем буюу цахим хэлбэрээр судалгаа авах ажлыг Мэдээлэл, технологийн газар, “Ухаалаг шийдэл” ХХК-тай хамтран шинээр нэвтрүүлж, тайлант хугацаанд нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын хүрээнд 2 удаа судалгаа авч дүнг нэгтгэн ажилласан.

5.1.3 Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.1.3 дахь заалт, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 5-6 дахь хэсэг “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын чиг үүргийн хуваарилалт, түүний хэрэгжилтийн байдалд дүн шинжилгээг үе шаттай хийнэ.”

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолоор “Албан тушаалын тодорхойлолт шинэчлэн боловсруулах нийтлэг журам” батлагдан гарсантай холбогдуулан газрын даргын 2019 оны А/24 дүгээр тушаалаар томилогдсон ажлын хэсэг захиргааны 17, байр ашиглалтын албаны 12, үйлчилгээний албаны 25, нийт 54 албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулсан.

Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 5-17 дахь хэсэг “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын төрийн албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулна.”

НИТХ болон Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/01 захирамжаар 2019 оныг “Иргэдийн оролцоотой-Хөгжлийн жил” болгон зарласантай холбогдуулан Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газар нь “Байгууллагын хөгжил-Үйлчилгээний чанар”-ын жил болгон, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг нийт 4 бүлгийн хүрээнд 12 зорилтот ажил хийж гүйцэтгэн төлөвлөн, биелэлтийг 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдөр НЗДТГ-ын Төрийн захиргааны хэлтэст хүргүүлэн ажилласан.

Зорилтот жилийн хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажлуудаас дурьдвал:

Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг ажилтан, албан хаагчдад таниулах, ёс зүйн дүрмийг дагаж мөрдүүлэх ажлын хүрээнд сургалт 10, мэдээллийн цаг 3 зохион байгуулж 195 ажилтан, албан хаагч хамрагдсан.



Зураг 1. Ёс зүйн сургалтын үеийн зургаас тоймловол

Төрийн албан хаагчдын ажиллах ая тухтай орчин нөхцөлийг бүрдүүлэх, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх талаар ажилтан, албан хаагчдаас гаргасан шинэ санал санаачилгыг дэмжин идэвхжүүлэх зорилгоор “Соёлтой үйлчилгээ-Бүтээлч санаа” сэдэвт болзолт уралдааныг 1 сарын хугацаатай зарлаж, уралдааны хүрээнд багууд өөрсдийн байруудын онцлогт тохируулан гадна болон дотор талын тохижилт, зүлэгжүүлэлт, засвар үйлчилгээг өөрсдийн нөөц бололцоогоор хийж гүйцэтгэсэн.



Зураг 2. НЗЗ-ын 5 дугаар байрны А корпусын гадна талбайн тохижилтын ажил



Зураг 3. НЗЗ-ны 2-р байр Хангарди ордны угтахын хаягжуулалт



Зураг4. НЗЗ-ны 5В байрны гаднах хайсыг гэрлийн бүрхүүлийн хаягдал ашиглан хийв

Эрүүл амьдрах хандлага, зан үйлийг төлөвшүүлэх, ажлын байрны ажиллах нөхцөлийг сайжруулах ажлын хүрээнд:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит 15-64 насны хүн амын бие бялдарын хөгжил, чийрэгжилтийн төвшинг тогтоох сорилыг 2019 оны 04 дүгээр сар,, өдөр зохион байгуулж 202,;

НИТХ, НЗДТГ, ЧДЭМТ, “Оном” сан хамтран 2019 оны 05 дугаар сарын 07-ны өдөр эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, сургалт сурталчилгааны өдөрлөгийг зохион байгуулж 141;

Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төв, “Монос фарм трейд” ХХК-тай хамтран 2019 оны 05 дугаар сарын 28-30-ны өдөр урьдчилан сэргийлэх үзлэгийг /усны дэлгэрэнгүй шинжилгээ, рентген зураг, хэвлийн эхо, зүрхний цахилгаан бичлэг, цусан дах сахар хэмжих, умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэг/ зохион байгуулж 250 гаруй;

Мөн Захиргаа, санхүүгийн хэлтэс, Биеийн тамир спортын хамтлаг “Илүүдэл жингээ хаяцгаая” сэдэвт болзолт уралдааныг 2019 оны 09 дүгээр сарын 10-ны өдрөөс 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн хугацаанд зохион байгуулж 30 гаруй ажилтан, албан хаагч тус тус хамрагдсан.

5.1.6 Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.1.6 дахь заалт, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 5-11 дэх хэсэг “Төрийн албан хаагчдын ёс зүйг дээшлүүлнэ.”

Засгийн газрын 2018 оны “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 258 дугаар тогтоол, ЗГ-ын 2019 оны 03 дугаар хурлын тэмдэглэл, Нийслэлийн Засаг даргын 2018 оны “Сахилга хариуцлага, дэг журмыг сайжруулах тухай” 03 дугаар албан даалгаварын хүрээнд ажилтан, албан хаагчдын сахилга, хариуцлага, дэг журмыг чангатгах үүднээс дараах арга хэмжээг авч ажиллалаа. Үүнд:

- Хөдөлмөрийн дотоод журмыг шинээр батлагдсан хууль тогтоомж, дүрэм журамд нийцүүлэн шинэчлэн боловсруулж, сахилгын зөрчил, хөдөлмөрийн гэрээг шууд цуцлах ноцтой зөрчлийг тодорхой болгосон.
- Газрын ёс зүйн дүрмийг “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-д нийцүүлэн шинэчлэн боловсруулсан.

- Газрын даргын “Сахилга дэг журмыг чангатгаж, хариуцлагыг өндөржүүлэх тухай” 2019 оны А/27 дугаар тушаалыг нийт ажилтан, албан хаагчдаар мөрдүүлэх, сахилга, хариуцлагыг өндөржүүлэх ажлыг зохион байгуулсан.
- Засгийн газрын 2018 оны “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 258 дугаар тогтоол, Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, Нийслэлийн Засаг даргын 2018 оны “Сахилга хариуцлага, дэг журмыг сайжруулах тухай” 03 дугаар албан даалгаврыг ажилтан, албан хаагч бүр мөрдөн ажиллалаа. Тайлант хугацаанд ёс зүйн зөвлөл 7 удаа хуралдаж 12 асуудал хэлэлцэж шийдвэрлэсэн. Үүнээс 1 албан хаагчид Хөдөлмөрийн тухай хуулийн 131.1.1, 1 албан хаагчид Хөдөлмөрийн тухай хуулийн 131.1.2, 7 албан хаагчид Хөдөлмөрийн тухай хуулийн 131.1.3-д зааснаар сахилгын шийтгэл ногдуулж, 3 албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах шаардлагагүй гэж үзсэн. Өмнөх 2018 оны мөн үетэй харьцуулахад




График 1. Ёс зүйн зөрчлийн тоог өнгөрсөн оны мөн үетэй харьцуулсан байдал

Төрийн албан хаагчдыг сургах, хөгжүүлэх, чадавхжуулах мөн тэдний ажиллах нөхцөл бололцоог бүрдүүлэхэд чиглэсэн “Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр 2018-2020” болон байгууллагын сургалт, нийгмийн баталгааг хангахад чиглэсэн ажлын төлөвлөгөөний хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

Төрийн албан хаагчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх, мэргэшүүлэх ажлын хүрээнд:

- Тайлант хугацаанд ёс зүйтэй холбоотой сургалт 10, мэргэжлийн сургалт 14, ажлын туршлага солилцуулах сургалт 2 тус тус зохион байгуулж давхардсан тоогоор 497 ажилтан, албан хаагч хамрагдсан. Мөн 7 удаагийн мэдээллийн цагаар мэргэжлийн байгууллагын 11 багш урьж ажилтан, албан хаагчдад цаг үеийн холбогдолтой асуудлаар зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.

Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд:

- Ажилтан, албан хаагчдын ар гэрт гарсан гачигдлыг харгалзан 28 ажилтан, албан хаагчид өргөдлийн дагуу буцалтгүй мөнгөн тусламж үзүүлсэн.
- Гэр болон галалгаатай байшинд амьдардаг ажилтан, албан хаагчдад түлээ, нүүрс авахад нь хөнгөлөлт, тусламж үзүүлэх 176 ажилтан албан хаагчдад түлшний хөнгөлөлт үзүүлсэн.

Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөлийг хангах ажлын хүрээнд:

- Байгууллагын үйл ажиллагааны явцад үүссэн бүх төрлийн архивын баримтын хадгалалтын технологийн горимд тавигдах үндсэн шаардлага, хадгалалтын тохиромжтой нөхцлийг бүрдүүлэх зорилгоор архивын өрөөнд өргөтгөл хийж, нягтруулсан шүүгээ 2, тавиур 2 тус тус шинээр байрлуулж, архивын байнгын хадгалалт, хамгаалалтын орчин, нөхцөлийг хангалаа.

5.2 Иргэддээ үйлчилдэг төр-Ухаалаг төрийн үйлчилгээ

5.2.1 Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.2.1 дэх заалт, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 5-18 дахь хэсэг “Иргэн хуулийн этгээдэд үзүүлж буй үйлчилгээг сайжруулна.”

Байгууллагын хэмжээнд дагаж мөрдөх “Хоол цайны үйлчилгээнд тавигдах ерөнхий шаардлага ННҮГ-02:2019”, “Ажлын байрны цэвэрлэгээ үйлчилгээний ерөнхий шаардлага ННҮГ-01:2019”, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ерөнхий шаардлага ННҮГ-03:2019”-ыг тус тус шинэчлэн боловсруулж газрын даргын 2019 оны А/18 дугаар тушаалаар батлан, өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилласан.

5.2.9 Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.2.9 дэх заалт, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 5-30 дахь хэсэг “Төрийн зарим үйлчилгээнд хөндлөнгийн үнэлгээ хийж, иргэдийн үнэлгээний картын систем, үйлчилгээний соёл, стандартыг шинэчлэнэ.”

Нийслэлийн Засаг захиргааны 5-н байр, НҮНТ-ийн 5-н салбаруудын өдөр тутмын цэвэрлэгээ үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, үйлчилгээний болон инженер техникийн ажилтан, албан хаагчдын өдөр тутмын ажлын гүйцэтгэл, түүнд тавих хяналтыг сайжруулах зорилгоор “Хяналтын хуудас” болон “Үнэлгээний карт”-ын системийг 2019 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс нэвтрүүлэн амжилттай хэрэгжүүлэн ажилласан.

НИЙСЛЭЛИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖИЛТНЫ ЦЭВЭРЛЭГЭЭ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНЭЛГЭЭНИЙ КАРТ

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГААНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ЦЭВЭРЛЭГЭЭ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРЫН ХЯНАЛТЫН ХУУДАС

Үйлчилгээ авч буй газар:		Ажилтны нэр:		Хариуцсан дахвар:		Харуусан дахвар:		2019 оны ... сар																															
Илчлэх ажилтны нэр:		Харууссан дахвар:		Харууссан дахвар:		Харууссан дахвар:		Нийт үнэлгээг гаргахдаа хувьчилж гаргах:																															
Хариуцсан дахвар:		Харууссан дахвар:		Харууссан дахвар:		Харууссан дахвар:		Нийт үнэлгээг гаргахдаа хувьчилж гаргах:																															
Гүйцэтгэлийн өгнөө	Ажлын гүйцэтгэлийн чанар	Ажилтны харилцаа, хандлага, өс зүйл	Үнэлгээ өгсөн ажилтны албан тушаал, гарын үсэг	Санаал, хүсэлт	Дүнх үнэлгээ	Үзүүлэлт тус бүрт өгөх өгнөө	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26	27	28	29	30	31		
2019.05.31	Сайн	Дунд	Муу	Сайн	Дунд	Муу																																	
2019.06.28																																							
2019.07.31																																							
2019.08.30																																							
2019.09.30																																							
2019.10.31																																							
2019.11.29																																							
2019.12.30																																							

Дүнхүснэ: Байр хариуцсан менежер: _____ / _____ /

Зураг 5. “Үнэлгээний карт”, “Хяналтын хуудас”

5.3.9 Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.3.9 дэх заалт, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 5-43 дахь заалт “Нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний байгууллагуудын дотоод хяналтын үйл ажиллагааг үнэлж, холбогдох арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжүүлэх замаар байгууллагуудын дотоод хяналтын тогтолцоог сайжруулна”.

Байгууллагын дотоод үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх 2019 оны хяналт-шинжилгээ үнэлгээний ажлын төлөвлөгөөний дагуу жилийн эцсийн

байдлаар 8 удаа зохион байгуулж, тайлант хугацаанд нийт 84 төрлийн ажил сайжруулах зөвлөмж өгч, хэрэгжилтийн биелэлтийг гаргуулан авч, гүйцэтгэлд биечлэн хяналт тавьсан. Тайлант хугацаанд тусгайлан хийх хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг дараах чиглэлээр зохион байгуулсан. Үүнд:

- Үйлчилгээний албаны үйл ажиллагаанд 03-р сард хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дундаж гүйцэтгэл 84,6% байсан ба ажил сайжруулах зөвлөмж 15,
- Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд 04-р сард хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дундаж гүйцэтгэл 78% байсан ба ажил сайжруулах зөвлөмж 13,
- Эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээнд 05-р сард хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дундаж гүйцэтгэл 85,6% байсан ба ажил сайжруулах зөвлөмж 9,
- Байр ашиглалтын албаны үйл ажиллалаанд 07-р сард хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дундаж гүйцэтгэл 93,6% байсан ба ажил сайжруулах зөвлөмж 7,
- Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд 08-р сард хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дундаж гүйцэтгэл 77,7% байсан ба ажил сайжруулах зөвлөмж 10,
- Зоогийн газар, цайны газрын үйл ажиллагаанд 08-р сард хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дундаж гүйцэтгэл 88% байсан ба ажил сайжруулах зөвлөмж 16,
- Үйлчилгээний албаны үйл ажиллагаанд 12-р сард хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дундаж гүйцэтгэл 92,5% байсан ба ажил сайжруулах зөвлөмж 8,
- Байр ашиглалтын албаны үйл ажиллалаанд 12-р сард хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дундаж гүйцэтгэл 94,8% байсан ба ажил сайжруулах зөвлөмж 6-г тус тус өгч хэрэгжилтийг хангуулан ажиллалаа.

5.4 Тогтвортой бодлого-Хамтын ажиллагаа

5.4.7 Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.4.7 дахь заалт, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 5-57 дахь хэсэг “Улаанбаатар хотын гамшгийн эрсдлийг бууруулах үйл ажиллагааны төлөвлөгөө”-г үе шаттай хэрэгжүүлнэ.”

Байгууллагын 2019 оны Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулан Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын газартай хамтран 04 дүгээр сарын 22-ны өдөр батласан.

Тайлант хугацаанд Монгол Улсын Засгийн газар, Онцгой байдлын ерөнхий газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран нийслэл хотын хэмжээнд зохион байгуулагдсан Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийн хүрээнд 2019 оны 04 дүгээр сарын 02-18-ны өдрүүдэд Нийслэлийн нийтлэг үйлчилгээний

газрын 38 ажилтан, албан хаагч жагсаалын бэлтгэл хангуулах дадлага сургалтанд, 2019 оны 04 сарын 24 өдөр нээлтийн ажиллагааны нэгдсэн жагсаалд амжилттай оролцсон.



Зураг 6. Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийн нээлтийн арга хэмжээ

4. НИЙГМИЙН ХӨГЖИЛ

4.4 Нийтийн биеийн тамир, спорт

4.4.3 Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.4.3 дахь заалт, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 4-84 дэх хэсэг “Улаанбаатар марафон 2019” олон улсын гүйлтийг зохион байгуулна”.

Тав дахь жилдээ зохион байгуулагдаж буй “Улаанбаатар Марафон - 2019” олон улсын гүйлтийг зохион байгуулах тухай” Нийслэлийн Засаг даргын А/440 дүгээр захирамжийн дагуу 2019 оны 05 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулагдсан “Улаанбаатар Марафон-2019” олон улсын гүйлтийн тэмцээнд тус газрын 88 ажилтан, албан хаагч идэвхтэй оролцсон.



Зураг 7. “Улаанбаатар марафон 2019” олон улсын гүйлтийн тэмцээний үеэр

Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 4-85 “Нийслэлийн иргэдийн спортын VIII наадмыг 8 төрлөөр, Хэсэг, Хороо, Бүс, Дүүрэг, Нийслэл гэсэн 5 үе шаттайгаар зохион байгуулна.” ажлын хүрээнд:

Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын Биеийн тамир спортын хамтлаг нь нийтийн биеийн тамирыг сурталчилах, ажилтан, албан хаагчдын бие бялдрыг чийрэгжүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хамт олны нөхөрлөлийг бэхжүүлэх зорилгоор батлагдсан удирдамжийн дагуу байгууллагын аварга шалгаруулах 4 төрөлт спортын наадмыг жил бүр уламжлал болгон зохион байгуулан явуулж байна.

Газрын даргын 2019 оны А/31 дугаар тушаалын дагуу 2019 оны байгууллагын аварга шалгаруулах спортын наадмыг 2019 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр ширээний теннис, дартс, 05 дугаар сарын 05-ны өдөр гар бөмбөг, сагсан бөмбөг гэсэн 4 төрлөөр тус тус зохион байгуулсан ба байгууллагын 9 багийн 90 гаруй тамирчид хурд, хүчээ сорьж оролцсоноос гадна багуудын хөгжөөн дэмжигчдийн 9 багийн 90 гаруй ажилтан, албан хаагч идэвхтэй оролцсон.



Зураг 8. Байгууллагын биеийн тамир, спортын наадмын үеэр

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Хууль тогтоомж, НИТХ-ын тогтоол, нийгэм эдийн засгийн зорилт, Нийслэлийн Засаг даргын захирамж, үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийн явц үр дүнг тайлагнаж ажиллах

Захирамжлалын баримт бичгийн хэрэгжилтийг хангаж ажиллах ажлын хүрээнд:

Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоол, НЗД-ын 2016 оны А/335 дугаар захирамжаар баталсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам”-ын дагуу тайлант хугацаанд нийт 34 төрлийн захирамжлалын баримт бичгийн 97 зүйл заалтын хүрээнд тайлан мэдээг бэлтгэж, сар улирлаар заасан хугацаанд www.monitoring.ulaanbaatar.mn цахим сайтад байршуулахын зэрэгцээ Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст цахим болон цаасан суурьтайгаар хүргүүлж ажилласан.

Нэг. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн 10/2091 дугаартай “Ажил эрчимжүүлэх тухай” албан бичгийн дагуу 6 захирамжлалын баримт бичгийн 28 заалтын хүрээнд хэрэгжүүлсэн ажлын тайланг бэлтгэж, газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлснээр цаасан суурьтайгаар болон цахим хэлбэрээр НЗДТГ-ын ХШҮХ-т хүргүүлсэн.

Хүснэгт 1

Д/д	Захирамжлалын баримт бичгийн төрөл	Захирамжлалын баримт бичгийн тухай	Хамаарах зүйл заалт	Тайлан өгсөн давтамж
1	Улсын Их Хурлын тогтоол	1. “Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай” /№2016-51/	1	2
2	Засгийн газрын тогтоол	2. “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт - шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам” батлах тухай /№2017-89/	2	1
		3. 2018 оныг “Хариуцлагын жил” болгон зарлах тухай /№2018-32/	6	1
		4. Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай /№2018-258/	11	2
		5. Журам батлах тухай /№2018-352/	1	1
		6. Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм батлах тухай /№2019-33/	1	2
		7. 2019 оныг “Эх оронч худалдан авалтын жил болгох тухай” /№2019-59/	1	1
3	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	8. Монгол улсын Засгийн газраас зарласан “Хариуцлагын жил”-ийн хүрээнд зохион байгуулсан ажлын тайлангийн талаар /№2019- 03-1/	9	2
		9. Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг үнэлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулсан дүнгийн тухай	11	2

		/№2019- 03 – I/		
		10. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн тайлангийн тухай /№2019-05-XX.I/	1	1
4	Засгийн газрын албан даалгавар	11. Хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангах тухай /№2018-01/	3	1
5	Удирдах ажилтнуудын улсын зөвлөгөөнөөс өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх төлөвлөгөө	12. Орон нутгийн удирдах ажилтны улсын зөвлөгөөнд Монгол улсын Ерөнхий сайдын өгсөн үүрэг, даалгаврыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад зохион байгуулсан үйл ажиллагааны биелэлт	8	4
6	НИТХ-ын тогтоол	-	-	
7	НИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол	13. “Нийслэлийн эрх зүйн мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх журам” батлах тухай /№2017-90/	3	1
		14. Иргэдийн амьдрах орчны аюулгүй байдлыг ханган чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай /№2018-11/	3	2
		15. Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийн явцыг дүгнэх, 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг батлах тухай /№2018-19-16/	1	1
8	Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хурлын тэмдэглэл	16. Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын 2019.08.01-ний өдрийн тэмдэглэл /№2019-18/01/	1	1
		17. Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын 2019.04.04-ний өдрийн тэмдэглэл /№2019-08/03/	1	1
		18. Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын 2019.06.24-ний өдрийн тэмдэглэл /№2019-15/11/	1	1
9	Нийслэлийн Засаг даргын захирамж	19. Төлөвлөгөө батлах тухай /№2019-А/66/	2	2
		20. Төрийн албаны тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай /№2019-А/1212/	2	2
		21. Зөвлөмж хүргүүлэх тухай /№2019-А/749/	1	2
		22. Нийслэлийн хэмжээнд төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг зохион байгуулах тухай /№2019-А/518/	4	2
		23. Теле хяналтын камеруудыг суурилуулах, түүнд хяналт тавих тухай	2	2

		24. Орчны аюулгүй байдлыг хангах зорилгоор хашаа, хайсыг буулгах ажлыг зохион байгуулах тухай /№2019-А/321/	1	2
		25. Нийслэлийн төр, захиргааны байгууллагуудын ажлын цагийн хуваарьт зохицуулалт хийх тухай /№2019-А/417/	1	1
		26. Ажлын цагийн хуваарьт зохицуулалт хийх тухай /№2019-А/339/	1	1
		27. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай /№2019-А/275/	1	1
		28. Төсвийн хуваарьт зохицуулалт хийх тухай /№2019-А/265/	1	1
		29. Тээврийн хэрэгсэл данснаас хасах тухай /№2019-А/172/	1	1
10	Нийслэлийн Засаг даргын албан даалгавар	30. Сахилга, хариуцлага, дэг журмыг сайжруулах тухай /№2018-03/	6	2
		31. Иргэдийг болзошгүй эрсдэлд өртөхөөс сэргийлэх талаар авах зарим арга хэмжээний тухай /№2019-04/	4	4
11	Нийслэлийн Онцгой комиссоос өгсөн үүрэг даалгавар	32. Нийслэлийн Онцгой комиссын 7 дугаар хурлын тэмдэглэл	1	2
		33. Нийслэлийн Онцгой комиссын 11 дүгээр хурлын тэмдэглэл	2	2
		34. Нийслэлийн Онцгой комиссын 12 дугаар хуралдааны тэмдэглэл	1	2
Нийт		34	97	55

Хоёр. Нийслэлийн Засаг даргын захирамж, Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хуралдааны тэмдэглэл, Нийслэлийн Засаг даргын албан даалгаврын хэрэгжилтийн тайлан мэдээг сар бүр гаргаж, тогтоосон хугацаанд гаргаж, холбогдох байгууллагад хүргүүлж ажиллах төлөвлөгөөний дагуу 16 захирамжлалын баримт бичгийн 20 заалтын хэрэгжилтийн мэдээг сарын бүрийн 05-ны өдрийн дотор бэлтгэж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст цахим суурьтайгаар хүргүүлсэн.

Хүснэгт 2

Д/д	Захирамжлалын баримт бичгийн төрөл	Захирамжлалын баримт бичгийн тухай	Хамаарах зүйл заалт	Тайлан өгсөн давтамж
1	Нийслэлийн Засаг даргын захирамж	1. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам батлах тухай /№2017-А/335/	1	12
		2. 2019 оныг “Иргэдийн оролцоотой – Хөгжлийн жил” болгон зарлах тухай /№2019-01/	1	12

		3. Төлөвлөгөө батлах тухай /№2019-А/66/	1	12
		4. Төсвийн хэрэгжилтийг зохион байгуулах талаар авах зарим арга хэмжээний тухай /№2018-А43/	2	12
		5. Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийн хүрээнд сургалт зохион байгуулах тухай /№2019-А/89/	1	2
		6. Нийслэлийн төр, захиргааны байгууллагуудын ажлын цагийн хуваарьт зохицуулалт хийх тухай /№2019-А/417/	1	2
		7. Худалдан авах ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах зарим арга хэмжээний тухай /№2018-А/333/	1	12
		8. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын 2018 оны ажил дүгнэх тухай /№2019-А/52/	1	12
		9. “Теле хяналтын камеруудыг шинээр суурилуулах, түүнд хяналт тавих тухай” /№2019-А/395/	1	6
		10. Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай /№2019-А/409/	1	1
		11. “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” /№2019-А/1016/	1	2
2	Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хурлын тэмдэглэл	12. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн 2018 оны жилийн эцсийн тайлангийн тухай /№2019-1/	1	12
		13. 2019.01.24-ний өдрийн 03 дугаар хуралдааны тэмдэглэл /№2019-03/	1	12
		14. 2019.04.04-ний өдрийн 08 дугаар хуралдааны тэмдэглэл /№2019-08/	1	6
		15. 2019.08.21-ний өдрийн 19 дүгээр хуралдааны тэмдэглэл /№2019-19/	1	4
3	Төлөвлөгөөний биелэлт	16. Монгол улсын Засгийн газрын 2018 оны 258 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлт	4	12
Нийт		16	20	131




График 2. Тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн мэдээг өмнөх онтой харьцуулсан байдал

- Сар, улирал, хагас бүтэн жилээр мэдээ тайлан гаргах захирамжлалын баримт бичиг 1 дахин, зүйл заалтын тоо 3.6 дахин нэмэгдсэн;
- Нийслэлийн удирдах ажилтны шуурхайн зөвлөгөөнөөс өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг өмнөх жилийн мөн үетэй харьцуулахад 3 дахин нэмэгдсэн;

Нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн мэдээг тухай бүр www.ulaanbaatar.mn цахим системд байршуулах төлөвлөгөөний хүрээнд:

2019 оны 01 дүгээр сарын 07-ны өдрөөс 2019 оны 12 дугаар 10-ны өдрийн хугацаанд 20 удаа болсон Нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнөөс Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газарт үүрэгжүүлсэн 96 ажлын хэрэгжилтийн мэдээг www.ulaanbaatar.mn сайтад 14 хоног тутам байршууллаа. Мөн шуурхайн зөвлөгөөнөөс өгсөн үүрэг даалгаврыг тухай бүр байгууллагын мэдээллийн самбарт байршуулж ажилласан.




График 3. Шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг даалгаврын мэдээг өмнөх онтой харьцуулсан байдал

ГУРАВДУГААР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН**Байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүргийн хүрээнд:**


Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газар нь Нийслэлийн Засаг даргын 2016 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн А/666 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын дүрэм шинэчлэн батлах тухай” дүрэмд тусгасан дараах 7 үндсэн чиг үүргийн дагуу НИТХ, НЗДТГ, Захирагчийн ажлын алба, хэрэгжүүлэгч агентлагууд болон Нийслэлийн Засаг захиргааны байруудад төрийн албан хаагчдын ажиллах ая тухтай орчин нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна.

3.1 Захиргаа, дотоод ажлын чиглэлээр

Нийслэлийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх, иргэн төвтэй төрийн үйлчилгээг дээдэлж, нийслэлийн иргэдийн өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээ шаардлагад нийцүүлэн төрийн үйлчилгээний чанар, төрийн байгууллагын чадавх, төрийн албан хаагчийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх зорилтын хүрээнд 2019 оныг “Иргэдийн оролцоотой-Хөгжлийн жил” болгосонтой холбогдуулан Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газар нь 2019 оныг “Байгууллагын хөгжил-Үйлчилгээний чанар”-ын жил болгон зарлаж үйл ажиллагаагаа уялдуулан ажиллаж Нийслэлийн засаг захиргааны байруудын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд үйлчилгээ, техникийн ажилтнуудын оролцоог нэмэгдүүлж, шинэ санал санаачилгыг дэмжин, идэвхжүүлэн урамшуулж ажиллалаа.

3.1.1 Хүний нөөцийн чиглэлээр:

Хүний нөөцийн ил тод байдлыг хангах чиглэлээр ажлын байрны сул орон тоог байгууллагын цахим хуудас www.khangardi.mn болон зарын нэгдсэн цахим хуудас www.unegui.mn, www.biznetwork.mn, байгууллагын мэдээллийн ил тод байдлын самбарт тухай бүр байршуулж нийтэд мэдээллэхийн зэрэгцээ ажлын байрны зарыг Хөдөлмөр эрхлэлтийн газар болон дүүргүүдийн Хөдөлмөр халамж, үйлчилгээний хэлтэст жилийн эцсийн байдлаар 28 удаа хүргүүлэн ажилласан байна. 2019 оны жилийн байдлаар дээрх хөдөлмөр зуучлалын мэдэгдэл, зараар ирсэн нийт 75 иргэний материалаас сонгон шалгаруулт хийж 50 хүн шинээр ажилд орсон байна. Шинээр ажилд орж байгаа ажилтнуудад газрын холбогдох дүрэм, журам, албан тушаалын тодорхойлолтыг танилцуулж, хөдөлмөрийн гэрээгээр ажиллуулж байна.



Зураг 9. Нээлттэй ажлын байрны зар

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 05 дугаар тогтоолоор баталсан төрийн албан хаагчийн хувийн хэргийг шинэчлэх, бүрдэл хангах ажлын хүрээнд нийт 289 ажилтан, албан хаагчдын шинээр ажилд ороход шаардагдах А, хувийн мэдээллийн Б анкетууд, хувь хуний намтарыг тус тус шинэчлэн боловсруулсан.

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолоор баталсан албан тушаалын тодорхойлолтыг нийт 53 ажлын байрны албан тушаалын тодорхойлолт боловсруулсан.

Мөн тайлант хугацаанд ажилтан, албан хаагчидтай холбоотой 11 төрлийн судалгааг гаргаж ажилласан:

- Ажилтан, албан хаагчдын дэлгэрэнгүй судалгаа;
- 0-15 насны хүүхдүүдийн судалгаа;
- Байгууллагаас өндөр насны тэтгэвэрт гарсан ажилтан, албан хаагчдын судалгаа;
- Ажилтан, албан хаагчдаас урьд өмнө нь авсан шагнал урамшууллын судалгаа;
- Орон байрны нөхцөлийн судалгаа;
- Улсад ажилласан жилийг нийгмийн даатгалын дэвтрийг үндэслэн гаргасан судалгаа;
- Хугацаат цэргийн алба хаасан ажилтан, албан хаагчдын судалгаа;
- Байгууллагын гэр хороололд амьдардаг ажилтан, албан хаагчдын сайжруулсан түлш хэрэглэж буй судалгаа;
- Одонтой ээжүүдийн судалгаа;
- Жирэмсний амралт, хүүхэд асрах чөлөөтэй байгаа ажилтан, албан хаагчдын судалгаа;
- Өрх толгойлсон ажилтан, албан хаагчдын судалгаа;

Байгууллагын хэмжээнд 2019 онд ажлын бус цагаар өөрийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэн суралцаж байгаа дотоод ажил, сургалт хариуцсан ажилтан Ц.Үрэлмаа РОУДС-ын төрийн захиргааны менежмент, байр хариуцсан менежер Б.Номин-Эрдэнэ Монголын Үндэсний их сургуулийн бизнесийн удирлага, агентлаг хариуцсан ахлах нягтлан бодогч Б.Байгалмаа Шихихутаг их сургуулийн эрх зүйч мэргэжлээр тус тус магистр зэрэг хамгаалан төгссөн бол хүнсний бүтээгдэхүүн, хангамжийн нярав М.Батзаяа Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн бизнесийн удирдлагын магистрантурт, ДХҮША Т.Итгэл, байр хариуцсан менежер С.Алтанцэцэг нар нягтлан бодогч мэргэжлээр тус тус суралцаж байна.

Тайлант хугацаанд хүний нөөцийг чадавхжуулах зорилгоор нийт 25 удаа сургалт зохион байгуулсанаас мэргэжлийн 17, ажлын туршлага солилцуулах 2, хувь хүн, ёс зүйтэй холбоотой 6 сургалтыг тус тус төлөвлөсөн хуваарийн дагуу хийж, давхардсан тоогоор 535 ажилтан, албан хаагчид хамрагдсан байна.

Үүнээс “Үйлчилгээний ажилтны мэргэжлийн үнэмлэх, зэрэг олгох” сургалтанд 20 үйлчилгээний ажилтан хамрагдаж мэргэжлийн 3 дугаар зэргийн үнэмлэх гардан авсан байна. Үүнд:

- Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн төвтэй хамтран 2019 оны 03 дугаар сарын 11-ний өдөр “Хувь хүний хөгжил” сургалтад 45;
- Монголын зочид буудлын холбоотой хамтран 2019 оны 03 дугаар сарын 13-15-ны өдөр зөөгчийн ур чадвар дээшлүүлэх сургалтад 22;
- 2019 03 дугаар сарын 19-ны өдөр цэвэрлэгээ үйлчилгээний стандарт шинэчлэн боловсруулсантай холбоотой сургалтад 10;
- Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн төвтэй хамтран 2019 оны 03 дугаар сарын 15-ны өдөр “Ажлын байрны сэтшэл зүй, эмх цэгц” сургалтад 40;

- 2019 оны 03 дугаар сарын 21-нээс 04 дүгээр сарын 03-ны өдрүүдэд ТЗҮЭГ-аас зохион байгуулсан үйлчилгээний ажилтны мэргэжлийн үнэмлэх, зэрэг олгох сургалтад 20;
- 2019 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр Архивын газартай хамтран “Баримт бичиг боловсруулалт, албан хэрэг хөтлөлтийн стандарт” сэдэвт сургалтад 37;
- Монголын хоол үйлдвэрлэл, үйлчилгээний мэргэжлийн академитай хамтран 2019 оны 04 дүгээр 17, 19-ны өдрүүдэд тогооч нарын ажлын байрны давтан сургалтад 20;
- 2019 оны 05 дугаар сарын 07-ний өдөр үйлчилгээний ажилтнуудын ажлын туршлага солилцох сургалтад 15;
- 2019 оны 05 дугаар сарын 24-ний өдөр Аялал жуулчлалын газраас зохион байгуулсан “Баристагийн мэргэжлийн ур чадвар олгох” сургалтад 1;
- 2019 оны 06 дугаар сарын 05-ны өдөр ОУ-ын Хүний нөөцийн хөгжлийн академитай хамтран “Удирдахуйн ухаан” сэдэвт сургалтад 10;
- 2019 оны 06 дугаар сарын 07-ний өдөр зохион байгуулсан “Байгууллагын соёл, ажилтны харилцаа, хандлага” сэдэвт сургалтад 33;
- 2019 оны 06 дугаар сарын 08-11-ний өдрүүдэд Аялал жуулчлалын газраас зохион байгуулсан “Угтах үйлчилгээний стандарт” сургалтад 1;
- 2019 оны 06 дугаар сарын 07-ний өдөр Төрийн албаны зөвлөлтэй хамтран “Төрийн албаны тухай хуулийн нэмэлт өөрчлөлт” сэдэвт сургалтанд захиргааны албан хаагч 34;
- 2019 оны 08 дугаар сарын 21-ний “Ажлын байрны цэвэрлэгээ, үйлчилгээний стандартыг хэрэгжүүлэх, үйлчилгээний ажилтны ёс зүйг хангаж ажиллах нь” сургалтад 27;
- 2019 оны 08 дугаар сарын 21-ний “Архив, албан хэрэг хөтлөлтийн ерөнхий ойлголт” сургалтад 29;
- 2019 оны 08 дугаар сарын 21-ний “Мэдээллийн аюулгүй байдал” сургалтад 29;
- Төрийн албанаас 2019 оны 08 дугаар сарын 26-ны зохион байгуулагдсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах арга зүй” сургалтад 1;
- 2019 оны 09 дүгээр сарын 16-ны өдөр “Монгол хэлний зөв бичих дүрминий журамласан толь” сургалтад 37;
- 2019 оны 10 дугаар сарын 16-ны өдөр “Иргэн төвтэй төрийн үйлчилгээ” сургалтад 2;
- Монгол Улсын Сангийн яамнаас 2019 оны 10 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулсан “Ерөнхий гэрээний журмаар худалдан авах ажиллагааг зохион байгуулах нь” сургалтад 3;
- Төр, засгийн үйлчилгээ эрхлэх газраас 2019 оны 10 дугаар сарын 24-25-ны өдрүүдэд зохион байгуулсан Аймаг, нийслэлийн нийтлэг үйлчилгээний удирдах ажилтны сургалтад 3;
- Монгол Улсын Сангийн Яам, Дэлхийн банкттай хамтран 2019 оны 10 дугаар сарын 24, 25-ны өдрүүдэд “Төсөвт байгууллагын нягтлан бодогчдод мэдлэг олгох” сургалтад 8;
- 2019 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр “Ажлын байрны цэвэрлэгээ, үйлчилгээний стандартыг дагаж мөрдөх” сургалтад 18;
- ШУТИС-ын эрүүл мэндийн төвтэй хамтран 2019 оны 12 сарын 05-ны өдөр “Ажлын байрны эрүүл ахуй, цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийн бодисыг зөв найруулж хэрэглэх нь” сургалтад 45;

- 2019 оны 12 сарын 23-ны өдөр “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд хөрөнгийн орлого, зарлагын мэдээлэл оруулах нь” сургалтад 17 ажилтан, албан хаагчид тус тус хамрагдсан.



Зураг 10. Зохион байгуулагдсан сургалтуудын үеэр

Тайлант хугацаанд байгууллагын мэдээллийн цагийг 7 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 1524 ажилтан, албан хаагчдад хамрагдсан. Үүнд:

- БСШУЯ-ны Биеийн тамир, спортын бодлого төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн Ж.Тунгалаг “Дасгал хөдөлгөөн-эрүүл аж төрөхүй”, ОУ-ын Хүний нөөцийн хөгжлийн академийн захирал, хүний нөөцийн удирдлагын мэргэшсэн зөвлөх Н.Амаржаргал “Биеэ зөв авч явах хувийн соёл, эрүүл сэтгэлгээ, зөв хандлагатай ажиллаж, амьдрах ухаан” сэдвээр;
- Нийслэлийн Онцгой байдлын газрын сургалт, сурталчилгаа, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн дэд хурандаа Б.Чинбат “Гамшгаас хамгаалах менежментийн тогтолцоо, гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах арга хэмжээ” сэдвээр;
- “Төгс Баян Хүрээ” ХХК-ийн захирал Х.Баярмагнай “Ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй” сэдвээр;
- Улаанбаатар их сургуулийн Гэр бүл судлалын хүрээлэнгийн тэнхимийн эрхлэгч, доктор, дэд профессор Б.Оюун-Эрдэнэ “Хүүхдийн хүмүүжилд эцэг, эхийн оролцоо” сэдвээр;
- Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын сургалт, олон нийттэй харилцах хэлтсийн ахлах мэргэжилтэн Д.Болормаа “Эрүүл мэндийн даатгалын тухай хууль түүний үйлчлэл” сэдвээр;
- Агаарын бохирдолтой тэмцэх газрын ахлах мэргэжилтэн Г.Даваажаргал сайжруулсан шахмал түлшний хэрэглээ, нийлүүлэлтийн талаар, “Эрүүл зүрх-Эрүүл Улаанбаатар” төслийг хэрэгжүүлэгч, нийгмийн эрүүл мэндийг дэмжигч Оном сантай хамтран төслийн ажилтан нийгмийн эрүүл мэндийн ажилтан М.Мэндбаяр “Артерийн даралт ихсэлт, түүний эрсдэлт хүчин

зүйлсээс урьдчилан сэргийлэх”, “Стресс менежмент”, Нийслэлийн цагдаагийн удирдах газрын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтсийн ахлах мэргэжилтэн, хошууч Э.Баярбаясгалан “Зөрчлийн тухай хууль” сэдвээр;

- Ди Жи Би ХХК эм ханган нийлүүлэх төвийн эмч Б.Мөрөн “Томуу, томуу төст, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх мөн эмийн зохистой хэрэглээ”, Нийслэлийн цагдаагийн удирдах газрын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтсийн ахлах мэргэжилтэн, ахлах дэслэгч Б.Нямсүрэн “Цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” сэдвээр тус тус сургалт, мэдээ мэдээлэл өгсөн.



Зураг 11. Мэдээллийн цагийн үеэр

3.1.2 Тушаал шийдвэрийн талаар:

Тайлант хугацаанд /2019.12.10-ны өдрийн байдлаар/ газрын даргын А тушаал 80, Б тушаал 355 тус тус батлагдан гарсан байна.




График 4. Өмнөх оны мөн үетэй харьцуулсан байдал




График 5. Сүүлийн 3 жилд гарсан тушаалууд

3.1.3 Өргөдөл гомдлын талаар:

Манай байгууллага нь төрийн албан хаагчийн ажиллах ая тухтай орчин нөхцөлийг бүрдүүлэх үндсэн чиг үүрэгтэй байгууллага учир дотогш чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг. Энэ үүднээс иргэдийн эрх ашгийг хөндсөн шийдвэр гаргадаггүй ба байгууллагын ажилтан, албан хаагчдаас хөдөлмөрийн харилцаатай холбоотой асуудлаар 2019 онд 210 өргөдөл, гомдол хүлээн авсан бөгөөд шийдвэрлэлтийн дундаж хугацаа 3 хоног 17 цаг 13 минут болж өмнөх оны дундажаас 19.5%-иар буурсан байна.

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн зөрчил өмнөх онд 62 байсан бол энэ онд 2 болж 96.7%-иар буурсан ба 2019 онд өргөдөл гомдлыг өдөрт нь багтаан хүлээн аваагүй 1, явцын тэмдэглэл хөтлөөгүй 1 зөрчил тус тус бүртгэгдэж, хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн зөрчилгүй ажиллалаа.

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа:

- 2018 оны эхний хагас жилд 5 хоног 5 цаг 47 минут
- 2018 оны сүүлийн хагас жилд 4 хоног 11 цаг 25 минут
- 2019 оны эхний хагас жилд 3 хоног 19 цаг 21 минут
- 2019 оны сүүлийн хагас жилд 3 хоног 17 цаг 13 минут болж өмнөх оны дундажаас 19.5%-иар буурсан байна.

Хандалтын хувьд 2018 онд 234 өргөдөл бүртгэгдсэн бол 2019 онд 210 өргөдөл бүртгэгдэж, 10.2%-иар буурсан үзүүлэлттэй байна.




График 6. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа

Тайлант хугацаанд ирсэн өргөдлийг ангилан авч үзвэл:

- Хөдөлмөрийн хөлстэй холбоотой – 54
- Ажилд орох, чөлөөлөгдөхтэй холбоотой – 52
- Цалинтай болон цалингүй чөлөө хүсэхтэй холбоотой – 51
- Жирэмсний амралт хүсэхтэй холбоотой – 24
- Нийгмийн асуудал шийдвэрлүүлэх тухай – 26
- Бусад - 3




График 7. Ирсэн өргөдлийг төрлөөр ангилан харуулав

1.1.4 Архив, албан хэрэг хөтлөлтийн талаар:

1. Тайлант хугацаанд нийт 384 албан бичиг ирснээс хариутай 109, хариугүй 275 бичиг хүлээн авч холбогдох хэлтэс, албадад шилжүүлэн, шийдвэрлэлтэд хяналт тавин ажилласан. Хугацаа хэтэрсэн болон зөрчилтэй шийдвэрлэсэн албан бичиг байхгүй бөгөөд нийт ирсэн бичгийг 100% хугацаанд нь шийдвэрлэсэн.

Ирсэн албан бичгийг хэлтэс, албадаар нь ангилан хүснэгтээр харуулбал

Хүснэгт 3

№	Төрөл	Ирсэн бичгийн нийт тоо	Ирүүлсэн хэлбэр			Шийдвэрлэлт					
			Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвөөр бүртгэгдсэн бичгийн тоо	Байгууллагаар бүртгэгдсэн бичгийн тоо	Системээр бүртгэгдсэн бичгийн тоо	Хариутай	Хариугүй	Хугацаандаа хаасан	Шийдвэрлэлтийн шатанд байгаа	Хугацаа хэтэрсэн бичиг	Нийт ирсэн бичгийн шийдвэрлэлтийн хувь
1.	Удирдлага	15	1	0	12	2	13	12	1	0	100%
2.	Захиргаа санхүүгийн хэлтэс	298	5	22	271	98	200	195	5	0	100%
3.	Байр ашиглалтын алба	68	0	21	47	8	60	60	0	0	100%
4.	Үйлчилгээний алба	3	0	1	2	1	2	2	0		

4. Нийт ирсэн бичиг	384	6	44	334	109	275	269	6	0	100%
----------------------------	------------	----------	-----------	------------	------------	------------	------------	----------	----------	-------------


2. Тайлант хугацаанд 687 албан бичгийг дээд шатны байгууллага, нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, бусад гадны байгууллагад албан бичгийн стандарт, дүрэм, зааврын дагуу боловсруулж хүргүүлсэн ба Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын захирагчийн ажлын алба, Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газар, Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвүүдээс холбогдох газруудад явуулсан нийт 6586 албан бичгийг тус газрын 2 бичиг хүргэгч шуурхай хүргэж ажиллалаа.

Явсан албан бичгийг хэлтэс, албадаар нь ангилан хүснэгтээр харуулбал

Хүснэгт 4

№	Төрөл	Явсан бичгийн нийт тоо	Хариутай бичгийн тоо	Хариугүй бичгийн тоо	Хугацаа хэтрүүлж хариу ирүүлсэн	Шийдвэрлэх шатандаа	Хугацаа хэтэрсэн, хариу ирээгүй	Шийдвэрлэлтийн хувь
1.	Удирдлага	11	0	11	0	0	0	100%
2.	Захиргаа санхүүгийн хэлтэс	556	2	554	0	0	1	90%
3.	Байр ашиглалтын алба	79	0	79	0	0	0	100%
4	Үйлчилгээний алба	7	0	7	0	0	0	100
4.	Нийт явсан бичиг	653	2	651	0	0	1	92.31 %

Мөн байгууллагын хэмжээнд мөрдөж буй архив, албан хэрэг хөтлөлтийн стандарт, дүрэм, зааврыг гарын авлага хэлбэрээр бэлтгэн гаргаж ажилтан, албан хаагчдад тараасан.



Зураг 12. Гарын авлага

2019 оны хэмжээнд албан хэрэг хөтлөлт, баримт бичиг боловсруулалтад тавигдах үндсэн шаардлага, тамга тэмдэг, хэвлэмэл хуудсыг хэрэглэхэд гаргадаг нийтлэг алдаа, албан бичгийн найруулга зүй, “Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь” буюу зөв бичих дүрэмд орсон нэмэлт өөрчлөлт зэрэг танилцуулж мэдлэгийг олгох сургалтыг 3 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 100 гаруй албан хаагч хамрагдсан.



Зураг 13. Албан хэрэг хөтлөлттэй холбоотой сургалтын үеэр

3. 2018 онд үүсч хөтлөгдсөн 230 хадгаламжийн нэгжийг ХХНЖ-ын дагуу 2019 оны 1 дүгээр улиралд акт үйлдэн хүлээн авсан. Үүнээс цаасан суурьтай 217, тусгай төрлийн 13 хадгаламжийн нэгжийг байнга, түр хадгалахаар хугацаагаар ангилсан.

2018 оны ХХНЖ-ын дагуу хүлээн авсан баримтын нэгдсэн тоо мэдээ

Хүснэгт 5

Хэлтсийн нэр	Байнга хадгалах	70 жил хадгалах	Түр хадгалах	Тусгай төрөл	ХН-ийн тоо
Захиргаа, санхүүгийн хэлтэс	38	22	138	13	211
Байр ашиглалтын алба	2	-	5	-	7
Үйлчилгээний алба	2	-	10	-	12
Дүн	42	22	153	13	230

БНШКомиссын гишүүд 2019 оны 06 дугаар сарын 01-ээс 07 дугаар сарын 30-ны өдрүүдийн хугацаанд байгууллагын архивын хадгаламжийн санд нэгдсэн тооллого, эрдэм шинжилгээ техник боловсруулалтын ажил хийсэн. Тооллогын явцад байнга хадгалах 2016-2018 оны 104, 70 жил хадгалах 2008-2018 оны 56 буюу нийт 222 хадгаламжийн нэгжид дотоод товъёог болон баталгааны хуудас, нүүр хуудсыг шинээр хийж, хуудас дугаарласан. Түүх, эрдэм шинжилгээ, мэдээлэл лавлагааны ач холбогдолгүй гэж үзсэн хадгалах хугацаа дууссан баримтуудыг нягтлан шалгаж 630 кг бүхий 16 хэргийн 482 хадгаламжийн нэгжээр устгах хэргийн акт үйлдэж устгалаа.



Зураг 14. Устгах акт үйлдсэн бичиг баримтыг устгалд орууж байгаа байдал

Нийслэлийн Архивын газрын дэргэдэх БНШАЗКомиссын 2019 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 03 дугаар хурлаар 7-н данс бүртгэл болон байгууллагын архивын гэрчилгээ олгох журмын дагуу хэлэлцүүлэн батлуулж, байгууллагын архивын гэрчилгээг шинээр авсан.



Зураг 15. Шинээр авсан “Архивын гэрчилгээ”

Архивын баримтын эмх цэгц, бүрэн бүтэн байдал, байрны дотоод зохион байгуулалт, стандарт шаардлагын хадгалалт, хамгаалалтад тогтмол хяналт тавин архивын өрөөний цэвэрлэгээ үйлчилгээг график төлөвлөгөөний дагуу сард 4 удаа чийгтэй цэвэрлэгээ хийлгэж, улиралд нэг удаа хортон шавьж, мэрэгч амьтны устгалын хор цацуулж, ариутгал хийлгэн, чийг дулааныг 7 хоногт 2 удаа хэмжиж, агаарын урсгалыг тэнцвэржүүлэх тал дээр анхаарч, тогтмол бүртгэл хөтлөн ажилласан.

Мөн архивын өрөөнд хадгаламжийн сангийн хэмжээ, хадгалалт, аюулгүй байдлыг хангах зорилгоор хадгаламжийн сан, архивын өрөөг стандартын дагуу засвар үйлчилгээ хийн тохижуулж, стандартад нийцсэн төмөр шүүгээ 2ш, тавиур 2ш, галын хор, дулаан хэмжигч зэрэг шаардлагатай багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж суурилуулсан.



Зураг 16. Шинээр байрлуулсан шүүгээ болон тавиур



Зураг 17. Архивын хадгаламжийн сангийн тохижуулалт

Нийслэлийн Засаг даргын 2013 оны “Захирамжлалын баримтад цахим хувь үйлдэх тухай” А/452 дугаар захирамж, Нийслэлийн Засаг даргын 2015 оны "Архивын сан хөмрөгт нөхөн бүрдүүлэлт хийх ажлын нийтлэг журмыг батлах тухай" А/177 дугаар захирамжийн хэрэгжилтийн дагуу байгууллагын газрын даргын 2017-2018 оны А, Б тушаалыг архивын ArchiveEdoc цахим программд оруулж, 2017оны А/тушаал 01-35, 2018 оны А/тушаал 01-68, 2017 оны Б/тушаал 01-465, 2018 оны Б/тушаал 01-485 буюу нийт 1053 тушаалын тэргүү, агуулга, он цагийн хязгаарыг шинэчлэн, Нийслэлийн Архивын газраар хянуулах хангалттай үнэлгээтэй дүгнэгдэж батламж авсан.

Төгсгөлийн үндэсний архив	Төгсгөлийн үндэсний архив	Төгсгөлийн үндэсний архив	Төгсгөлийн үндэсний архив	Төгсгөлийн үндэсний архив	Төгсгөлийн үндэсний архив	Төгсгөлийн үндэсний архив	Төгсгөлийн үндэсний архив	Төгсгөлийн үндэсний архив	Төгсгөлийн үндэсний архив
100	010	Архивын хадгаламж	01	0002	Тайлбар	100	1	10	10
100	010	Архивын хадгаламж	01	0002	Тайлбар	100	2	10	10
100	010	Архивын хадгаламж	01	0002	Тайлбар	100	3	10	10
100	010	Архивын хадгаламж	01	0002	Тайлбар	100	4	10	10
100	010	Архивын хадгаламж	01	0002	Тайлбар	100	5	10	10
100	010	Архивын хадгаламж	01	0002	Тайлбар	100	6	10	10
100	010	Архивын хадгаламж	01	0002	Тайлбар	100	7	10	10
100	010	Архивын хадгаламж	01	0002	Тайлбар	100	8	10	10
100	010	Архивын хадгаламж	01	0002	Тайлбар	100	9	10	10
100	010	Архивын хадгаламж	01	0002	Тайлбар	100	10	10	10

Төгсгөлийн үндэсний архив	Төгсгөлийн үндэсний архив	Төгсгөлийн үндэсний архив	Төгсгөлийн үндэсний архив	Төгсгөлийн үндэсний архив	Төгсгөлийн үндэсний архив	Төгсгөлийн үндэсний архив	Төгсгөлийн үндэсний архив	Төгсгөлийн үндэсний архив	Төгсгөлийн үндэсний архив
100	010	Архивын хадгаламж	01	0002	Тайлбар	100	1	10	10
100	010	Архивын хадгаламж	01	0002	Тайлбар	100	2	10	10
100	010	Архивын хадгаламж	01	0002	Тайлбар	100	3	10	10
100	010	Архивын хадгаламж	01	0002	Тайлбар	100	4	10	10
100	010	Архивын хадгаламж	01	0002	Тайлбар	100	5	10	10
100	010	Архивын хадгаламж	01	0002	Тайлбар	100	6	10	10
100	010	Архивын хадгаламж	01	0002	Тайлбар	100	7	10	10
100	010	Архивын хадгаламж	01	0002	Тайлбар	100	8	10	10
100	010	Архивын хадгаламж	01	0002	Тайлбар	100	9	10	10
100	010	Архивын хадгаламж	01	0002	Тайлбар	100	10	10	10

Зураг 18 . 2017 оны А, Б тушаал шинэчилсэн байдал

The image contains two screenshots of a web application interface. The left screenshot shows a table with 165 rows, and the right screenshot shows a table with 1315 rows. Both tables have columns for various categories and numerical values. The tables are presented in a grid format with a search bar and navigation buttons at the top.

Зураг 19. 2018 оны А, Б тушаал шинэчлсэн байдал

Баримтыг хэлтэс, албадаас нэр төрөл, хугацаагаар нь төрөлжүүлэн ХХНЖ-ын дагуу цаасан суурьтай 217, тусгай төрлийн 13 хадгаламжийн нэгжийг хүлээн авсан.

Байгууллагын 2019 оны ХХНЖ-ыг БНШК-ын шийдвэрийн дагуу 2019 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр шинэчлэн газрын даргаар батлуулж ажилласан.

Мөн Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 150 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий сайдын 2019 оны 46 дугаар захирамж, Хууль зүй, дотоод хэргийн сайдын баталсан улсын үзлэг явуулах хуваарийн дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Нандинжаргалаар ахлуулсан ажлын хэсэг “Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг”-ийг 2019 оны 09 дүгээр сарын 23-25-ны өдрүүдэд Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газарт зохион байгуулсан. Тус үзлэгийн нэгдсэн дүнгээр манай байгууллага 94 хувь А буюу “Бүрэн хангалттай” үнэлэгдэж дүгнэгдсэн байна.



Зураг 20. Албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийн үеэр

3.1.5 Ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр:

Хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх, тогтвор суурьшлыг хангах, ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд байгууллагын дотоод журамд заасны дагуу 28 ажилтан, албан хаагчдад өргөдлийн дагуу буцалтгүй мөнгөн тусламжийг үзүүлсэн.

Мөн гэр болон галалгаатай байшинд амьдардаг ажилтан, албан хаагчдад түлээ, нүүрс авахад нь хөнгөлөлт, тусламж үзүүлэх 176 ажилтан албан хаагчдад түлшний хөнгөлөлт үзүүлсэн. Ажилтан, албан хаагчдын ар гэрт гарсан гачигдлыг шийдвэрлэснээрээ тэдний нийгмийн асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэх зорилтыг ханган, ажиллах нөхцөл бололцоог бүрдүүлж, хүний нөөцийн тогтвор суурьшилтай байдал хангагдаж байна.



Зураг 21. 176 ажилтан, албан хаагчдад түлшний хөнгөлөлт үзүүллээ

1-р улиралд 254 ажилтан, албан хаагчийг дүгнэж, 9 албан хаагч шинээр орсон шалтгаанаар дүгнэгдээгүй байна. Нийт албан хаагчаас 116 буюу 45.6 хувь нь 25%-иар, 81 буюу 31.8 хувь нь 20%-иар, 30 буюу 11.8 хувь нь 15%-иар, 14 буюу 5.5 хувь нь 10%-иар, 2-р улиралд 246 ажилтан, албан хаагчийг дүгнэж, 10 албан хаагч шинээр орсон шалтгаанаар дүгнэгдээгүй байна. Нийт албан хаагчаас 181 буюу 73,5 хувь нь 25%-иар, 39 буюу 15,8 хувь нь 20%-иар, 10 буюу 4 хувь нь 15%-иар, 2 буюу 0,8 хувь нь 10%-иар, 3 буюу 1,2 хувь нь 0%-иар, 3-р улиралд 255 ажилтан, албан хаагчийг дүгнэж, 17 албан хаагч шинээр орсон, 1 албан хаагч өвчтэй байсан шалтгаанаар тус тус дүгнэгдээгүй байна. Нийт албан хаагчаас 156 буюу 61,1 хувь нь 25%-иар, 54 буюу 21,1 хувь нь 20%-иар, 19 буюу 7,4 хувь нь 15%-иар, 3 буюу 1,1 хувь нь 10%-иар, 4 буюу 1,6 хувь нь 0%-иар тус тус дүгнэгдсэн байна.

3.1.6 Эрүүл мэндийн чиглэлээр:

Нийслэлийн эдийн засаг нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 5.17 дахь хэсэгт “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын төрийн албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулна” гэж заасны дагуу эрүүл мэндийн төрөлжсөн мэргэжлийн тусламж үйлчилгээг ажилтан, албан хаагчдад ойртуулах, урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо, эрт илрүүлэгт хамруулах, эрүүл мэндийн боловсрол олгох, мэдээлэл өгөх зорилгоор 2019 оны 05 дугаар сарын 28-30-ны өдрүүдэд “Эрүүл ажлын байр” аяныг зохион байгуулж, 250 гаруй ажилтан, албан хаагчийг нарийн мэргэжлийн эмчийн урьдчилан сэргийлэх үзлэг, зөвлөгөө мэдээлэл, эрүүл зохистой хооллолтын өдөрлөгт хамруулсан.




Зураг 22. “Эрүүл ажлын байр” өдөрлөгийн үеэр

Байгууллагын ажилтан, албан хаагчдаас бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилыг 2019 оны 1-р улиралд 7 үзүүлэлтээр авч, 205 ажилтан, албан хаагч буюу 82% нь хамрагдсан байна.



Зураг 23. Бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн төвшин тогтоох сорилын үеэр

Мэдээллийн цагаар БСШУЯ-ны Биеийн тамир, спортын бодлого төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн дэд профессор Ж.Тунгалаг “Дасгал хөдөлгөөн эрүүл аж төрөхүй” сэдвээр нийгмийн өмнө тулгамдаж буй асуудлуудын нэг болох хөдөлгөөний дутагдал, түүнээс үүдэлтэй таргалалт, бие бялдрын хувьд эрүүл байх зөвлөгөө зөвлөмжийг өгсөн.



Зураг 24. Дасгал хөдөлгөөн эрүүл аж төрөхүй сэдэвт сургалтын үеэр

Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын Захиргаа, санхүүгийн хэлтэс, Биеийн тамир спортын хамтлаг хамтран эрүүл, зөв амьдралын дадал олгох зорилгоор “Илүүдэл жингээ хаяцгаая” сэдэвт болзолт уралдааныг 2019 оны 09 дүгээр сарын 10-ны өдрөөс 10 дугаар сарын 10-ны өдрийн хугацаанд зохион байгуулж, 1 дүгээр байрт сувилагч Т.Шашиймаа /-6,3 кг/, 2 дугаар байрт байр ашиглалтын албаны дарга Г.Батзаяа /-5,4 кг/, 3 дугаар байрт орлогч дарга Ч.Однасан /-4,3 кг/ нар шалгарч, бооцооны мөнгөн шагналаа гардан авсан.



Зураг 25. Тэмцээний ялагчид шагналаа гардан авлаа

Нийслэлийн нийтлэг Үйлчилгээний газар нь НЗДТГ буюу НЗЗ-ны 1 дүгээр байранд байрлах цайны газар, НЗЗ-ны 2 дугаар байр буюу Хангарди ордоны зоогийн газар, НЗЗ-ны 5-р байрны цайны газруудаар дамжуулан нутгийн захиргааны байгууллагуудад ажиллаж буй төрийн албан хаагчдад нийтийн хоолны үйлдвэрлэл, үйлчилгээг үзүүлж ажилладаг бөгөөд 2019 онд органик хүнс ногоо, сонгино, сармисаар амталсан уураг, амин дэмээр баяжуулсан сувилалын хоол, үндсэн хоолоор үйлчилгээ үзүүлэн ажиллалаа.

Чихрийн шижингийн онош бүхий цөөн тооны алба хаагчдын хүсэлтээр Улсын клиникийн 2-р эмнэлэгийн хоол зүйч эмчээс зөвөлгөө авч, тусгайлан баталсан цэсийн дагуу хоолоор үйлчилж хэвшээд 3 дахь жилдээ ажиллаж байна.



Зураг 26. Сувиллын хоол

Нийслэлийн Засаг даргын тамгын газраас нийслэлийн харъяа байгууллагуудын дунд хамт олны эрүүл амьдрах хандлага, зан үйлийг төлөвшүүлэх, ажилчдын эрүүл мэндийг дэмжих орчинг бий болгох зорилгоор сүүлийн 3 дахь жилдээ “Эрүүл ажлын байр” удирдамжийг хэрэгжүүлж байгаа бөгөөд Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газар олон бүтээлч ажлыг санаачлан, хэрэгжүүлж ажилласанаар 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдөр “Эрүүл ажлын байр” бүрдүүлсэн байгууллагаар хоёрдугаар байрт шалгарч 2018, 2019 оны хошой 2 дугаар байрны эзэн болсон.



Зураг 27. Эрүүл ажлын байр бүрдүүлсэн шилдэг хамт олон боллоо

3.1.7 Биеийн тамир спортын талаар:

Нийслэлийн Засаг даргын А/440 дүгээр захирамжийн дагуу 2019 оны 05 дугаар сарын 18-ны өдөр “Улаанбаатар марафон-2019” олон улсын гүйлт 2019 онд 5 дахь жилдээ зохион байгуулагдаж тус тэмцээнд 88 ажилтан, албан хаагч идэвхтэй оролцсон.



Зураг 28. Улаанбаатар марафон 2019 тэмцээний үеэр

Газрын даргын 2019 оны А 31 дүгээр тушаалын дагуу биеийн тамир спортын хамтлаг нь нийтийн биеийн тамирыг сурталчлах, ажилтан, албан хаагчдын бие бялдрыг чийрэгжүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хамт олны нөхөрлөлийг бэхжүүлэх зорилгоор 2019 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр ширээний теннис, дартс, 05 дугаар сарын 05-ны өдөр гар бөмбөг, сагсан бөмбөг 4 төрөлт тэмцээнийг зохион байгуулж 9 багийн 90 гаруй тамирчид хурд, хүчээ сорьж оролцсон.





Зураг 29 . Байгууллагын биеийн тамир, спортын наадмын үеэр

Нийслэлийн 380 жилийн ойн хүрээнд Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагуудын дунд 2018 оны аваргаар шалгарч шилжин явах цомын эзэн болсон Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газар “СПОРТЫН НААДАМ”-ыг спортын гурван төрлөөр 2019 оны 11 дүгээр сарын 09,10-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулж спортын наадамд 11 агентлагын 290 тамирчид хурд хүч, авхаалж самбаагаа сорьсон. Тэмцээнд оролцсон багуудаас нийлбэр дүнгээрээ тэргүүн байрыг Хот байгуулалт, хөгжлийн газар эзэлж “ШИЛЖИН ЯВАХ ЦОМ”-ын эзэн болсон.





Зураг 30. Гурван төрөлт спорт наадмын үеэр

Биеийн тамир, спортын хамтлагийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах хүрээнд ажилтан, албан хаагчдын хөдөлгөөний хомсдолоос урьдчилан сэргийлэх зорилгоор НЗДТГ-ын спорт заалтай хамтран ажиллах хүсэлт хүргүүлсэн ба долоо хоногт 1.5 цаг зааланд хамт олноороо биеийн тамир спортоор хичээллэх гэрээ байгуулсан.



Зураг 31. Спорт зааланд тоглох үеэр

Эрүүл ажлын байр ажлын хэсгээс санаачлан эрүүл ажлын байр, эрүүл орчныг бий болгох зорилгоор ажлын байранд хийх дасгалыг НЗЗ-ны 2 дугаар байр буюу Хангарди ордонд ажиллаж буй ажилтан, албан хаагчдад 2019 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн өдөрт 2 удаа чанга яригчаар явуулж эхэлсэн.

Төр, засгийн үйлчилгээ эрхлэх газраас Аймаг, нийслэлийн нийтлэг үйлчилгээний байгууллагуудын удирдах ажилтны сургалт, семинарыг 2019 оны 10 дугаар сарын 24-25-ны өдрүүдэд зохион байгуулсан ба сургалтын 2 дахь өдөр буюу 25-ны өдөр Төр, засгийн үйлчилгээ эрхлэх газар, нийслэл, орон нутгийн үйлчилгээний байгууллагуудын хооронд дунд гар бөмбөг, дартсын нөхөрсөг тэмцээн зохион байгуулж, Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын спортын баг тамирчид амжилттай оролцон гар бөмбөгийн төрөлд тэргүүн байр эзэлж алтан медаль хүртсэн.



Зураг 32. ТЗҮЭГ-аас зохион байгуулсан тэмцээний үеэр

3.1.8 Өндөр настан, ахмадуудад хүндэтгэл үзүүлсэн талаар:

Жил бүрийн сар шинийн баяраар ННҮГ-аас гавъяаны амралтанд гарсан ахмадуудад хүндэтгэл үзүүлэн хүлээн авдаг уламжлалтай.

2019 оны сар шинийн баяраар 80 гаруй ахмадуудад хүндэтгэл үзүүлэн хүлээн авч, газрын дарга гарын бэлэг гардууллаа.



Зураг 33. Ахмадуудад хүндэтгэл үзүүлэх

Жил бүр аравдугаар сарын 1-ний өдөр Олон улсын ахмадын баярыг тохиолдуулан Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газарт ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэртээ гарсан 80 гаруй ахмадуудаа хүлээн авч хүндэтгэл үзүүлж, ахмад настан Ш.Минжүүр гуайн хөдөлмөр алдрыг тэмдэглэн, Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын “Хүндэт дэвтэр”-т алдаршуулан гэрчилгээ олгосон.

Арга хэмжээний үеэр Монголын Ахмадын холбооны “Хүндэт тэмдэг”-ээр ахмад настан Ш.Дэдээбазар, Ч.Цолмон, Нийслэлийн ахмадын хорооны “Хүндэт тэмдэг”-ээр Ц.Рэгмаа, Л.Долгорсүрэн, Н.Цэндсүрэн, Н.Дашбалдан нарын нийт 6 ахмадыг шагнаж урамшуулсан ба нийт ахмадуудаа цаашид бүх талаар дэмжиж хамтарч ажиллахаа илэрхийлж гарын бэлэг гардуулав.



Зураг 34. Ахмадуудад хүндэтгэл үзүүлэх үеэр

3.1.9 Санхүү, аж ахуйн чиглэлээр:

Төрийн үйлчилгээг хэвийн жигд тасралтгүй явуулахад шаардлагатай хөрөнгө санхүүг төлөвлөн зарцуулж, хөрөнгө материалын ашиглалт, хадгалалтанд хяналт тавин, ажил үйлчилгээний төсвийг хянан, хянагдаж батлагдсан төсөв хөрөнгийн төлбөр тооцооны гүйлгээг цаг хугацаанд нь хийж, төсвийн гүйцэтгэлийг батлагдсан хуваарийн дагуу зарцуулж, санхүүгийн сахилга батыг чанд мөрдөн ажилласан.

2019 оны 1, 2 дугаар улирлын тайлан, төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр гаргаж, тайлант хугацаанд нийт 5 удаагийн тайлан мэдээг хугацаанд нь НЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс, Нийслэлийн татварын газарт хүргүүлсэн. Төсвийн гүйцэтгэлийг батлагдсан хуваарийн дагуу зарцуулж, шилэн данс вэб хуудаст 27 төрлийн тайланг хугацаанд нь байршуулан ажилласан. Мөн байгууллагын захиргаа, санхүүгийн хэлтсийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд хийх хяналт шинжилгээ, үнэлгээг газрын даргын баталсан удирдамжийн дагуу хяналтын хуудасны 38 асуултын хүрээнд хийсэн. Хяналт шинжилгээ, үнэлгээ хийхдээ 2019 оны А/30 дугаар тушаалаар батлагдсан “Эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдсон бусад харилцааг зохицуулах журам” болон бусад эрх зүйн актуудыг удирдлага болгон ажилласан.

Ажлын хэсэг 1-р хэсэг буюу цалин хөлсний шалгуур үзүүлэлт 93%, 2-р хэсэг буюу үндсэн хөрөнгө, бараа материалын шалгуур үзүүлэлт 56%, 3-р хэсэг буюу бэлтгэн нийлүүлэгч болон бусад байгууллагатай хийсэн гэрээ хэлцэл, нийлүүлж байгаа бараа материал, үйлчилгээний баримтын иж бүрдэлийн шалгуур үзүүлэлт 75%, 4-р хэсэг буюу зоогийн газрын тооцооны талаар шалгуур үзүүлэлт 80%, 5-р хэсэг буюу бусад шалгуур үзүүлэлт 89%-ийн тус тус гүйцэтгэлтэй гэж дүгнэсэн ба зөвлөмжийн дагуу арга хэмжээ авч, хэрэгжилтийн талаарх тайланг 2019 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн дотор газрын даргын дэргэдэх зөвлөлийн хуралд танилцуулах үүргийг өгч ажилласан.

Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч 12 агентлагийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээг агентлаг хариуцсан ахлах нягтлан бодогч 6, агентлаг хариуцсан нярав 6 албан хаагчаар дамжуулан ямар нэгэн гомдол саналгүй иж бүрнээр үзүүлэн ажилласан.

Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын даргын 2018 оны А/55 тушаалаар байгуулагдсан Өмч хамгаалах байнгын зөвлөл нь 2019 онд жилийн эцсийн байдлаар 3 удаа хурлыг зохион байгуулсан. Хуралдаанаар:

- Хяналтын тооллогыг хийх

- Эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалттай холбоотой журам боловсруулах
- Бүртгэлгүй хөрөнгийг бүртгэлжүүлэх шийдвэрийг тус тус гаргаж хэрэгжилтийг хангаж ажилласан.

ННҮГ-ын даргын 2019 оны А/40 дүгээр тушаалаар 2019 оны эхний хагас жилийн эд хөрөнгийн тооллогыг хийх ажлын хэсгийг томилсон ба ажлын хэсэг актлах 34 нэр төрлийн аж ахуйн бараа материалын жагсаалтыг гаргаж, газрын даргын дэргэдэх зөвлөлийн 9-р хуралд танилцуулж шийдвэрлүүлсэн.

Жилийн эцсийн байдлаар 8 хүний бүрэлдэхүүнтэй тооллогын комисс гаран байгууллагын эд хөрөнгөний тооллогыг хийж гүйцэтгэлийн ажиллагаа явагдаж байна.

Тус газар нь тайлант хугацаанд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.2 дахь заалтад нийцүүлэн бараа, ажил, үйлчилгээ нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалтыг зохион байгуулан ажилласан.

“Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын 2019 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө”-ний дагуу бараа нийлүүлэх тендер 4 удаа, ажил гүйцэтгэх тендер 1 удаа, төлөвлөгөөнд тусгаагүй тендер 1 удаа, нийт 5 удаа тендер зохион байгууллаа. Үүнд:

- ННҮГ-т цэвэрлэгээний хэрэгсэл бэлтгэн нийлүүлэх ажил;
- ННҮГ-ын зоогийн газарт мах, махан бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэх ажил;
- НҮГ-ын зоогийн газарт хуурай хэрэгсэл бэлтгэн нийлүүлэх ажил;
- НҮГ-ын зоогийн газарт жимс жимсгэнэ, хүнсний ногоо бэлтгэн нийлүүлэх ажил;
- Нийслэлийн засаг захиргааны 5 дугаар байрны А корпусын дээврийн засварын ажил;
- Нийслэлийн засаг захиргааны 5 дугаар байрны В корпусын дээврийн засварын ажил.

Тендерийн урилгыг цахим хуудсанд тухай бүр байршуулан ил тод байдлыг ханган ажиллахын зэрэгцээ худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийг сар бүрийн 01-ний өдрийн дотор Худалдан авах ажиллагааны газарт, хэрэгжилтийн мэдээг улирал бүрийн сүүлийн сарын 25-ны өдрийн дотор Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлэн ажиллаж байна. Мөн тендер шалгаруулалт зохион байгуулж худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний талаарх мэдээг сар бүр www.shilendans.gov.mn цахим хуудсанд байршуулж буй болно.

Тайлант хугацаанд худалдан авах ажиллагаатай холбоотой ямар нэгэн зөрчилгүй, гуравдагч этгээдээс гаргасан гомдолгүй ажиллаа.

Тендер шалгаруулалтын үр дүнд худалдан авч буй бараа бүтээгдэхүүний 70 хувь нь Засгийн газрын 2015 оны 336 дугаар тогтоолоор баталсан “Дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар, стандартын шаардлага хангасан барааны жагсаалт”-д хамаарахаар байна.

3.1.10 Дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр:

Тогтоол шийдвэр, эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтэд хяналт тавьж дотоод хяналт шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх

нийтлэг журам”, Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/335 дугаар захирамжаар баталсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам”, 2014 оны А/279 дүгээр захирамжаар баталсан “Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам”, бусад холбогдох дүрэм, журам, баримт бичгийг тус тус удирдлага болгон ажилласан.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын талаар:

Бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 10 заалтын хэрэгжилтийг хяналтанд авч, шинжилгээ үнэлгээ хийж ажиллалаа. Хэрэгжилтийн дундаж үзүүлэлт нь 100%-ийн гүйцэтгэлтэй байна.

Тайлант хугацаанд УИХ-ын 1 тогтоолын 1, Засгийн газрын 6 тогтоолын 22 заалт, Засгийн газрын 2 хуралдааны тэмдэглэлийн 21 заалт, ЗГ-ын 1 албан даалгаврын 3, НИТХ-ын Тэргүүлэгчдийн 3 тогтоолын 7, Нийслэлийн Засаг даргын 19 захирамжийн 24 заалт, НЗД-ын 2 албан даалгаврын 10 заалт, НЗД-ын зөвлөлийн хурлын 4 тэмдэглэлийн 4 заалтын хэрэгжилтэд тус тус хяналт тавин ажиллалаа. Тогтоол шийдвэрийн хэрэгжилт 100%-ийн гүйцэтгэлтэй байна. Манай байгууллагад хамааралтай дээд газрын тогтоол шийдвэрийн тоо өмнөх оныхоос 45.6%-иар өссөн байна.

НЗД-ын 2016 оны А/666 дугаар захирамжаар батлагдсан Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын 7 чиг үүргийн хэрэгжилтэд улирал бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ажилласан ба 2019 онд 100%-ийн гүйцэтгэлтэй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн шууд захирагчтай байгуулсан үр дүнгийн гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж 2019 оны үр дүнгийн гэрээгээр гүйцэтгэхээр төлөвлөгдсөн 32 арга хэмжээ, 2 тусгай захиалгат бүтээгдэхүүнийг хяналтад авч гүйцэтгэлийн явцад улирал тутам хяналт тавин ажилласан.

Байгууллагын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 42 заалтын хэрэгжилтэд улирал тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж ажилласан ба хэрэгжилт хангалтгүй байгаа ажлыг эрчимжүүлэх үүргийг холбогдох албан хаагчдад өгсөн. 2019 оны жилийн эцсийн байдлаар хэрэгжилт 99.7%-ийн гүйцэтгэлтэй байна.

НЗДТГ-аас Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын 2018 оны ажилд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 20 заалтыг хэрэгжилтэд улирал тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн. 2019 оны жилийн эцсийн байдлаар тус төлөвлөгөөний хэрэгжилт 99.6%-ийн гүйцэтгэлтэй ажилласан.

Газрын даргын өгсөн үүргийн дагуу 2018, 2019 онд холбогдох албан хаагчдад хүлээлгэн өгсөн хангамжийн материал, багаж хэрэгсэлийн ашиглалтын байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг газрын шуурхай зөвлөгөөнд танилцуулсан.

Архивын газраас 2019 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн ирүүлсэн 02/525 дугаар албан бичгийн дагуу Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газраас 2019 онд явуулсан албан бичгүүдэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг илтгэх хуудсаар Архивын газарт хүргүүлсэн.

Тусгайлан хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын талаар:

2019 оны дотоод хяналт-шинжилгээ үнэлгээний ажлын төлөвлөгөөний дагуу тусгайлан хийх хяналт-шинжилгээг 8 удаа зохион байгуулж, дүнг газрын даргын

дэргэдэх зөвлөлийн хуралд танилцуулсан. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайлант хугацаанд нийт 84 төрлийн ажил сайжруулах зөвлөмж өгч, хэрэгжилтийн биелэлтийг гаргуулан авч, гүйцэтгэлд биечлэн хяналт тавьсан. Тайлант хугацаанд тусгайлан хийх хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг дараах чиглэлээр зохион байгуулсан.

- Үйлчилгээний албаны үйл ажиллагаанд 03-р сард хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дундаж гүйцэтгэл 84,6% байсан ба ажил сайжруулах зөвлөмж 15,
- Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд 04-р сард хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дундаж гүйцэтгэл 78% байсан ба ажил сайжруулах зөвлөмж 13,
- Эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээнд 05-р сард хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дундаж гүйцэтгэл 85,6% байсан ба ажил сайжруулах зөвлөмж 9,
- Байр ашиглалтын албаны үйл ажиллалаанд 07-р сард хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дундаж гүйцэтгэл 93,6% байсан ба ажил сайжруулах зөвлөмж 7,
- Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд 08-р сард хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дундаж гүйцэтгэл 77,7% байсан ба ажил сайжруулах зөвлөмж 10,
- Зоогийн газар, цайны газрын үйл ажиллагаанд 08-р сард хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дундаж гүйцэтгэл 88% байсан ба ажил сайжруулах зөвлөмж 16,
- Үйлчилгээний албаны үйл ажиллагаанд 12-р сард хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дундаж гүйцэтгэл 92,5% байсан ба ажил сайжруулах зөвлөмж 8,
- Байр ашиглалтын албаны үйл ажиллалаанд 12-р сард хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дундаж гүйцэтгэл 94,8% байсан ба ажил сайжруулах зөвлөмж 6-г тус тус өгч хэрэгжилтийг хангуулан ажиллалаа.

Сэтгэл ханамжийн судалгааны талаар:

Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын 3.1.6 дахь заалт /хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ хэрэглэгч, оролцогч болон олон нийтийн оролцоог хангасан байх/-ын хэрэгжилтийг хангах зорилгоор, үнэлгээний карт, зоогийн газруудад санал хүсэлтийн дэвтрийг ажиллуулж үйлчлүүлэгчдийн санал хүсэлтийг тогтмол авч ажиллахын зэрэгцээ хэрэглэгчийн үнэлгээг тогтоох зорилгоор нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас 2019 оны 05 дугаар сарын 30-ны өдрөөс 06-р сарын 06-ны өдрүүдэд 12 асуултын хүрээнд сэтгэл ханамжийн судалгааг явуулсан. Уг судалгаанд НЗЗ-ны байруудад байрлан үйл ажиллагаа явуулж байгаа нутгийн захиргааны 31 байгууллагын 707 ажилтан, албан хаагч оролцож, санал хүсэлтээ ирүүлсэн бөгөөд судалгаанд оролцогчдын 64% нь сайн, 28% нь дунд, 8% нь хангалтгүй үнэлгээ өгсөн. Дүнг даргын дэргэдэх зөвлөлийн 7-р хурлаар хэлэлцэж байр тус бүрт гарсан санал хүсэлтийг хэрэгжүүлж ажиллах үүргийг холбогдох албан хаагчдад өгсөн.

ННУГ-ын үндсэн чиг үүргийн хэрэгжилтэд хэрэглэгчдийн өгсөн үнэлгээ



График 8. Санал асуулгын дүн


Мөн зорилтод жилийн хүрээнд Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын үйл ажиллагааг сурталчилах, дүрмээр хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хийлгэх, хэрэглэгчдийн санал хүсэлтийг нээлттэйгээр хүлээн авч, хурдан шуурхай шийдвэрлэх зорилгоор газрын даргын 2019 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр баталсан удирдамжийн дагуу “Таныг сонсьё” аяныг 2 дахь жилдээ зохион байгууллаа. Тус аяныг 2019 оны 12 дугаар сарын 02-ны өдрөөс 06-ны өдрийн хугацаанд зохион байгуулсан бөгөөд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Байгууллагын танилцуулга, аяны тухай мэдээллийг шторк хэлбэрээр бэлтгэж, НЗЗ-ны байрууд, НҮНТ-ийн салбаруудад нийтийн эзэмшлийн талбайд байрлах дэлгэцээр тогтмол хугацаанд явуулах,



Зураг 35. Байгууллагын танилцуулга явагдаж байгаа байдал

- Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын дотоод удирдлагын нэгдсэн системд “Таныг сонсьё” аянд идэвхтэй оролцож, цахим судалгаанд саналаа өгөхийг уриалсан мэдээлэл байршуулсан. Тус мэдээллийг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын ажилтан, албан хаагчдаас 86 дэмжиж, 27 сэтгэгдэл үлдээсэн байгаа нь дэмжлэг ихээр авсан байгааг харуулж байлаа.



Зураг 36. ERP системд байршуулсан мэдээлэл

- Үйлчилгээний алба, Байр ашиглалтын албаны ажилтнууд байгууллагын лого бүхий “Таныг сонсьё” аяныг илтгэсэн таних тэмдгийг зүүж, үйлчлүүлэгчдээс ирүүлсэн санал хүсэлтийг нээлттэйгээр хүлээн авч, холбогдох албан хаагчид танилцуулж, богино хугацаанд шийдвэрлүүлж ажилласан.



Зураг 37. Үйлчилгээний ажилтнууд “Таныг сонсьё” аяны энгрийн тэмдэг зүүсэн байгаа нь

- НЗЗ-ын байрууд, НҮНТ-ийн салбаруудад үйл ажиллагаа явуулж байгаа нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын ажилтан, албан хаагчдаас сэтгэл ханамжийн судалгааг цахим хэлбэрээр авсан.

“Таныг сонсьё” аянд НЗЗ-ны 5 байр, НҮНТ-ийн 4 салбаруудын 683 ажилтан, албан хаагч оролцож санал хүсэлтээ илэрхийлсэн ба манай байгууллагын үйл ажиллагаанд санал асуулгад оролцогчдын 68% нь сайн, 27% дунд, 5% нь хангалтгүй үнэлгээ өгсөн байна.




График 9. “Таныг сонсьё” аяны хүрээнд ирүүлсэн санал асуулгын дүн




График 10. Эхний хагас жил, сүүлийн хагас жилийн судалгааны дүнгийн харьцуулалт

Графикаас харахад манай байгууллагын үйл ажиллагаанд эхний хагас жилд өгсөн үнэлгээнээс сүүлийн хагас жилд өгсөн үнэлгээ сайжирсан байгаа нь харагдаж байна.

Цаг ашиглалтын талаар:

Засгийн газрын 2018 оны “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 258 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2018 оны “Сахилга хариуцлага, дэг журмыг сайжруулах тухай” 03 дугаар албан даалгаврын хүрээнд Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын даргын дэргэдэх зөвлөлийн шийдвэрээр ажилтан, албан хаагчдын цаг ашиглалтад авах арга хэмжээ, түүний хариуцлагын тогтолцоог ур чадварын нэмэгдэлтэй нь уялдуулан тооцож байхаар шийдвэрлэсэн.

Цагийн бүртгэлийн мэдээг хурууны хээ мэдрэх төхөөрөмжөөс сар бүр гарган авч 2019 оны 11 дүгээр сарын байдлаар давхардсан тоогоор ажлаас хоцорсон 178 ажилтан, албан хаагчид 3 төрлийн сануулах хуудсыг тарааж анхааруулсан. Мөн ажилтан албан хаагчдын ур чадварыг үнэлэхдээ сануулах хуудас авсан байдлыг тооцон үнэлж, цаг ашиглалтын тухай мэдээллийг ажилтан албан хаагчдад тогтмол мэдээллэж ажилласан.




График 11. 2019 онд ажлаас хоцорсон ажилтан, албан хаагчид

Графикаас харахад ажлаас хоцорсон ажилтан албан хаагчдын тоо 2019 оны сүүлийн саруудад 2019 оны эхний саруудаас буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь цаг ашиглалтын талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүнг харуулж байна.

Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын даргын 2019 оны А/73 дугаар тушаалаар захиргаа, санхүүгийн хэлтсийн албан хаагчдын 2019 оны жилийн эцсийн ажлын үр дүнг үнэлж дүгнэх ажлын хэсгийг томилсон. Ажлын үр дүнг дүгнүүлэх 45 албан хаагчаас 40 албан хаагчийн ажлыг дүгнэж, 1 албан хаагч чөлөөтэй шалтгаанаар дүгнэгдээгүй ба 4 албан хаагчийг газрын дарга дүгнэлээ. Үр дүнг дүгнүүлсэн албан хаагчаас А үнэлгээтэй 18, В үнэлгээтэй 17, С үнэлгээтэй 4 албан хаагч байлаа.

3.2 НЗЗ-ны байруудын инженерийн байгууламжийн ашиглалт, ус, дулаан, цахилгаан, хурлын танхимуудын техник, тоног төхөөрөмжийн хэвийн, найдвартай ажиллагааг ханган ажиллах чиглэлээр:

ННҮГ-ын Байр ашиглалтын алба нь албаны дарга 1, инженер 3, нийт 44 хүний бүрэлдэхүүнтэйгээр НЗЗ-ны 5 байр, НҮНТ-ийн 4 салбарын ус, дулаан, цахилгаан, мужааны засвар үйлчилгээ, инженерийн байгууламжийн хэвийн найдвартай, жигд ажиллагааг ханган ажиллаж, НЗЗ-ны 5-н байранд байрлан төрийн үйлчилгээ үзүүлж буй Нийслэлийн нутгийн захиргааны 34 агентлагтай

“Байр ашиглалтын гэрээ” болон “Гүйцэтгэх гэрээ” байгуулан гэрээний дагуу ажил, үйлчилгээг 24 цагаар тасралтгүй шуурхай үзүүлж ажиллаж байна.

Инженерийн шугам сүлжээг эвдрэл гэмтлээс урьдчилан сэргийлэх үзлэгийг орлогч дарга, албаны дарга сард 1 удаа, инженерүүд 7 хоног тутам тус тус тогтмол хийж, инженерийн байгууламжийн хэвийн ажиллагаанд хяналт тавьж, техникийн болзошгүй саатлаас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, гамшгаас хамгаалах төлөвлөгөө, НЗЗ-ны байруудын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах төлөвлөгөө, хаврын тохижилтийн ажлын төлөвлөгөө зэргийг боловсруулан, хэрэгжилтийг ханган ажилласан.

Тайлант хугацаанд НЗЗ-ны 5 байр, НҮНТ-ийн 4 салбараас нийт 4704 дуудлага ирсэнээс мужааны 1476, цахилгааны 960, сантехникийн 1368, холбоо дохиоллын 900 дуудлагыг цаг алдалгүй шуурхай барагдуулж ажиллалаа.




График 12. БАА-нд ирсэн нийт дуудлагыг 2018, 2019 оны эхний хагас жилийн байдлаар харьцуулан харуулав

2018 онд инженерийн шугам сүлжээ, цахилгаан, мужаан, холбооны 3349, 2019 онд 4704 дуудлага бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 1355 дуудлагаар буюу 40.45%-иар буурсан үзүүлэлттэй байна.

3.2.1 Цахилгаан хангамжийн чиглэлээр:

НЗЗ-ны байруудын цахилгааны шугам сүлжээний хэвийн ажиллагааг хангах, эвдрэл гэмтлээс урьдчилан сэргийлэх үзлэгийг тогтмолжуулж, цахилгаан ашиглалттай холбоотой 960 дуудлага ирснийг шуурхай засварлаж ажилласан.

НЗЗ-ны 5-н байранд лед гэрэл 813ш, өдрийн гэрэл 292ш, шигтгээ гэрэл 35ш, бууруулагч 50ш, автомат салгагч 45ш, розетка 81ш, вилка 15ш, унтраалга 47ш, шалны розетка 60ш, цахилгааны монтажийн утас 390 метр, далдлагч 59 ширхэгийг тус тус үзлэг, дуудлагын дагуу сольж, шинэчилж ажилласан байна. Мөн НЗЗ-ны байруудын гадна фасадны гэрэлтүүлгийн жигд ажиллагааг хангах, рекламны гэрэлтүүлгийг цагийн релегээр удирдах ажиллагааг жигдрүүлснээр цахилгаан, эрчим хүчний хэрэглээг 2018 оныхоос 4%-иар бууруулсан хэмнэлт гаргасан.

НЗЗ-ны байруудын цахилгаан эрчим, хүчний аюулгүй байдлыг хангах, хэмнэлтийг бий болгох, цахилгааны хэвийн ажиллагааг хангах зорилгоор Зүүн Цахилгаан Түгээх салбартай хамтран ажиллах гэрээний дагуу тоолуур, гүйдлийн тр-р баталгаажуулах хуваарилах байгууламжуудын тоолуурыг шинээр сольж, ил гарсан цахилгааны болон, холбоо, сүлжээний утсыг далдалж аюулгүй байдлыг бүрэн ханган ажилласан.

Цахилгаан, эрчим хүчний аюулгүй, хэвийн ажиллагааг хангах зорилгоор 2019 онд зарим засварын ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Тухайлбал:

НЗЗ-ны 1 дүгээр байрны 1, 2, 3 давхрын нийтийн эзэмшлийн талбайд галын хор 36ш, аваарийн болон ЕХИТ гэрэл 60ш-г тус тус шинээр суурилуулсан.

НЗЗ-ны 2 дугаар байр буюу Хангарди ордны 1-16 давхрын нийтийн эзэмшлийн талбайд галыг хор 30ш цэнэглэж байнгын бэлэн байдалд оруулж, 6, 8, 14, 15-р давхрын хуваарилах группын самбарын дифференциаль автомат салгагчуудыг сольж хэвийн ажиллагаатай болгосон. Мөн төв хаалганд халуун хөшиг 1ш шинээр суурилуулж цахилгааны схемд холбож, хурлын А болон Б заал, Чуулганы танхимд цахилгааны монтажийг шинэчилсэн.



Зураг 38. НЗЗ-ны 2-р байр буюу Хангарди ордны ачаалал даахгүй автомат салгуурыг шинэчилсэн байгаа байдал



Зураг 39. Хангарди ордны шинэ автомат контактор

НЗЗ-ны 3 дугаар байрны 1-5 давхар хүртэл нийтийн эзэмшлийн талбайд ослын гэрэл 22ш, галын хор 22ш, Exit гэрэл 8 ш-г шинээр суурилуулсан ба цахилгааны ерөнхий щитний оруулгын болон давхрын самбарлуу гарсан кабелийн төгсгөвч шатсан байсныг бүрэн шинэчлэн аюулгүй ажиллагааг бүрэн хангалаа.



Зураг 40. Щитний оруулгыг шинэчлэн сольсон байдал

НЗЗ-ны 4 дүгээр байрны 1-13 дугаар давхрын нийтийн эзэмшлийн талбай коридорт галын хор 7 ширхэг, ослын гэрэл 24 ширхэг, гарцын гэрэл 24 ширхэгийг хийж шинэчилсэн байна.

НЗЗ-ны 5-р байрны гадна талын ерөнхий кабелийн гэмтэлийг цахилгааны гэмтлийн илрүүлэх лабораториор тодорхойлж, холболтын муфьт хийж аюулгүй ажиллагааг хангасан. Мөн тус байрны А, Б корпусын хооронд цахилгааны кабель, цитийг угсарч цахилгааны ачааллыг бууруулж, фазыг тэнцвэржүүллээ.

Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн “Оргил” салбарын 220 вольт цахилгаан эрчим хүчийг 380 вольт болгон цахилгаан эрчим хүчийг сайжруулж, хөргөлтийн систем шинээр суурьлуулж, төрийн албан хаагчдын ажиллах ая тухтай орчин нөхцөлийг бий болгосон.

3.2.1 Сантехник, инженерийн шугам сүлжээний чиглэлээр:

Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газар нь тайлант хугацаанд НЗЗ-ны байрууд, НҮНТ-ийн сантехникийн шугам сүлжээ, агааржуулалтын хоолойн хэвийн найдвартай ажиллагааг ханган ажиллаж, нийт 1368 дуудлагыг бүртгэн шуурхай барагдуулж ажилласан бөгөөд 2019 оны 10-р сарын 01-ний өдрөөс 12-р сарын 15-ны өдрийг хүртэл хугацаанд НЗЗ-ны байруудын халаалтыг цаг агаарын нөхцөл, байдалтай холбогдуулан 30-50 градус буюу бага градуст тохируулж ажиллаж, ус дулааны зардлаас нийт 77,187,764 төгрөгийг хэмнэлээ. Сантехник, инженерийн шугам, сүлжээний хэвийн, найдвартай ажиллагааг хангах зорилгоор зарим засварын ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Тухайлбал:

“Хүй долоо худаг” 4*12-н хэмжээтэй зөөврийн сууцны халуун усны бойлер шинээр суурилуулж, гал тогоонд ажиллаж байгаа ажилтнуудын ажиллах нөхцөлийг сайжрууллаа.



Зураг 41. Зөөврийн сууцанд халуун усны бойлер шинээр суурилуул байгаа байдал

Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах, НЗЗ-ны байруудын халаалтыг авахад бэлтгэл ажлыг хангах зорилгоор НЗЗ-ны 1, 2, 3, 4, 5-р байруудын халаалт, дулаан, хэрэглээний усны тоолуурыг тус тус Монгол улсын стандартад нийцсэн тоолуураар шинэчлэн сольж, баталгаажуулсан.

НЗЗ-ны 1, 3, 4, 5-р байруудын 4 ширхэг хурдны ус халаагч, задардаггүй ялтсан бойлерыг салгаж, угаалга цэвэрлэгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн.

НЗЗ-ны 1-р байранд хэрэглээний хүйтэн усны гаднаас оруулах шугам уэль дотор байрлах аваарын хаалт барихгүй болсныг шинэ Ф80 хаалтаар шинэчилж

сольсон ба мөн хуучирсан төгсгөвч таглаа цоорсон байсныг шинээр засварлаж, хэвийн аюулгүй ажиллагааг хангасан.



Зураг 42. Төгсгөвч таглаа засварлаж байгаа нь

НЗЗ-ны 2-р байр буюу Хангарди ордны 15 давхарын зоогийн газарт халуун усны даралт муу байсныг даралтын насос нэмж байрлуулж хэвийн ажиллагааг бүрэн хангасан тус байрны цэвэр усны босоо шугам, угаагуурын салбар шугамуудыг шинэчилж, угсрах ажлыг хийж гүйцэтгэлээ.



Зураг 43. Цэвэр усны босоо шугам, угаагуурын салбар шугам

НЗЗ-ны 2-р байрны 1-15 давхрын ариун цэврийн өрөөний угаагуурын уян холбоосууд шаардлага хангахгүй болсон байсныг сольж шинэчлэн хэвийн ажиллагааг хангасан.



Зураг 44. Ариун цэврийн өрөөний уян холбоос

Хангарди ордны гадна талын явган хүний замд байрлах бохирын худаг, гараж руу орох орц, гарцын эргэлтийн ханын чулууг тус тус засварласан.



Зураг 45. Засварын ажлын үеэр

НЗЗ-ны 2-р байрны узелийн халаалтын системийн ерөнхий шугамд даралт мэдрэгч манометр, температур мэдрэгч, даралт мэдрэгч автомат зэргийг шинээр сольж суурилуулж, хэвийн ажиллагаанд өдөр тутам хяналт тавих нөхцөл боломжийг хангалаа.



Зураг 46. Хэмжигч суурилуулсан байдал

НЗЗ-ны 3-р байрны дулааны узельд халаалтын болон хэрэглээний халуун усны шугамд Ф50 хоолой 4метр, Ф50 булан 2ширхэг, Ф80 хаалт, Ф100 хаалт, Ф80 хог шүүгч, манометр, термометр шинээр сольж хэвийн ажиллагааг хянах боломжийг бүрдүүлсэн ба хэрэглээний халуун усны автомат хаалт эвдэрсэн байсныг сольсон.



Зураг 47. Засварын ажлын үеэр

НЗЗ-ны 4-р байрны дулааны узелийн халаалтын шугамын хаалтууд, хагарсан шугам, хоолойг сольж, хэвийн ажиллагааг хангалаа.



Зураг 48. Засварын ажлын үеэр

Мөн НЗЗ-ны 5-р байрны 1-р давхрын кофе шопын орчмоос үнэртэж байсан бохирын үнэрийн шалтгааныг тогтоож, шугам хоолойг шинээр залгаж, бохирын үнэрийг бүрэн арилгаж засварын ажлыг гүйцэтгэлээ.



Зураг 49. Засварын ажлын үеэр

БАА-ны слесариуд НЗЗ-ны 5-р байр буюу Улаанбаатар чуулгын 1-р давхрын нийтийн ариун цэврийн өрөөг бүрэн тоноглол бүхийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан орчинг бий болгож тохижуулсан.



Зураг 50. Засварын ажлын үеэр

НЗЗ-ны 5-р байрны дээврийн засварын ажлыг гүйцэтгэгчийг төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу сонгон шалгаруулж, “Дэлгэр ган” ХХК, “БЭЗБ” ХХК-тай тус тус ажил гүйцэтгэх тухай гэрээ байгуулж, гэрээний гүйцэтгэл хяналт тавьж ажилласан ба газрын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг тус ажлыг хүлээж авсан. Мөн тус байрны В корпусын үүдний саравчны дээврийн засварын ажлыг гүйцэтгэлээ.



Зураг 51. Дээврийн засварын ажлын үзэр

3.2.3. НЗЗ-ны байруудын хурлын танхимуудын техник хэрэгслүүдийн хэвийн ажиллагааг хангах чиглэлээр:

НЗДТГ, Хангарди ордон болон НЗЗ-ны 5В байранд байрлах Иргэний танхимын хурлын заалуудаар жилийн эцсийн /2019.12.10-ны/ байдлаар 1530 хурал хүлээн авч ажилласан. Хурал хүлээн авсан байдлыг хүснэгтээр харуулбал:

НЗДТГ буюу НЗЗ-ны 1 дүгээр байрны хурлын заалаар нийт 774 хурал, уулзалтын захиалга ирснээс А танхимд 432 хурал, Б танхимд 164 уулзалт, шагнал гардуулах үйл ажиллагаа, VIP танхимд 178 тусгай уулзалт тус тус хүлээн авч графикт оруулан ажилласан.

Хүснэгт 6

Нийслэлийн Засаг даргын Тамгын газар		
№	Хурлын чиглэл	Хуралдсан тоо
1.	ННТХ тэргүүлэгчийн хурал	31
2.	Засаг даргын уулзалт болон хурал	79
3.	Хурлын даргын уулзалт болон хурал	53
4.	Төрийн болон нийслэлийн шагнал	25
5.	Нийслэлийн онцгой комиссын хурал	7
6.	Захирагчийн ажлын албаны шуурхай	3
7.	Нийслэлийн цэргийн штабын шуурхай	11
8.	Бусад	565

Хангарди ордны 14 давхрын хурлын танхимаар НИТХ 18, НЗД-н шуурхай 18, НЗД-ын зөвлөлийн хурал 21, ЗАА шуурхай 22, шагнал болон гарын үсэг 31, бусад хурал 556 нийт 666 удаа хурал, шагнал, бусад арга хэмжээнүүдийг зохион байгуулсан.

Хүснэгт 7

Хангарди ордон		
№	Хурлын чиглэл	Хуралдсан тоо
1.	Удирдлагын зөвлөлийн хурал	21
2.	Нийслэлийн шуурхай	18
3.	ЗАА шуурхай	22

4.	Шагнал	31
5.	НИТХ-ын чуулган	18
6.	Бусад	556

НЗЗ-ны 5 дугаар байр буюу Иргэний танхимд хурал, семинар, мэдээллийн цаг, шагнал зэрэг нийт 90 удаагийн үйл ажиллаг хүлээн авсан.

Хүснэгт 8

Иргэний танхим		
№	Хурлын чиглэл	Хуралдсан тоо
1.	Хурал, семинар, чуулган	30
2.	Ёслол хүндэтгэлийн үйл ажиллагаа	12
3.	Техникийн зөвлөгөөн	2
4.	Шагнал	31
5.	Мэдээллийн цаг	6
6.	Сургалт	35
7.	Дуудлаг худалдаа	2




График 13. Хурлын төрлөөр авч үзвэл

Хурлын танхимуудын камер, дэлгэц, микрофон, өсгөгчүүдийг шинээр сольж, Хангарди ордны 14 давхрын хурлын А, Б зааланд ханын дуу чимээ тусгаарлагч хавтан (акустик), мөн шаланд хивсэнцэр хавтан хийж, хурлын заалны тоног төхөөрөмж, орчныг сайжрууллаа.



Зураг 52. Хурлын заалыг засварласан байдал



Зураг 53. Хурлын заалны тоног, төхөөрөмжийн шинэчлэл

3.2.4 Бусад үйл ажиллагааны хүрээнд:

Хянагч операторууд холбоо болон сүлжээний 412 удаагийн дуудлагыг хүлээн авч, гарсан гэмтэл доголдлыг шуурхай завсарлаж, НЗЗ-ын байруудад 24 цагаар телекамерын хяналт тавиж ажиллах нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна.

Байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөх ЗГ-ын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой бодлого, шийдвэр, бусад цаг үеийн шинжтэй хийгдсэн ажлуудын талаархи мэдээ, мэдээллийг тухай бүр нь байгууллагын цахим хуудаст www.khangardi.mn/ нээлттэйгээр байршуулж ажилласан. Тайлант хугацаанд сайтад газрын шуурхай зөвлөгөөн болон бусад үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээлэл 75, дүрэм, журам, стандарт 6-г шинээр байршуулж ажилласан бөгөөд НЗДТГ-ын ХШҮ-ний хэлтсээс Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын цахим хуудсын мэдээлэлд Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхий тухай хууль, Засгийн газрын 2013 оны 411 дүгээр тогтоол, 2009 оны 143 дугаар тогтоолд заасны дагуу 22 шалгуур үзүүлэлтээр үнэлгээ хийсэн. Тус үнэлгээнд Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газар 3 байрт үнэлэгдсэн байна.

НЗЗ-ны 2, 4 дүгээр байруудын хүн зөөврийн болон ачааны бш цахилгаан шатны ашиглалт, засвар үйлчилгээг сар бүр гэрээт байгууллагаар гүйцэтгүүлж, аюулгүй ажиллагааг бүрэн ханган ажиллаж байна.

Байр ашиглалтын албанаас 2019 онд нийтдээ 7 удаа 5, 8, 10 ханатай иж бүрэн тавилгатай гэр, асар, майхан зэргийг барьж угсрах, хурааж, буулгах, зөөж тээвэрлэх ажлыг Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны норм дүрэмд заасныг баримтлан осол гэмтэлгүй хийж гүйцэтгэсэн.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн “Төрийн байгууллагын стандарт хаяг, гадна хаягны стандарт” батлах тухай А/897 дугаар захирамжийг хэрэгжилтийг хангах зорилгоор НЗЗ-ны байруудын гадна хаягийг сольж, шинэчиллээ.



Зураг 54. НЗЗ-ны байруудын гадна хаягийг стандартын дагуу шинэчилсэн байдал

3.3 Нийслэлийн Засаг захиргааны байруудын цэвэрлэгээ, үйлчилгээ, эрүүл ахуйд нийцсэн зоогийн үйлчилгээний чиглэлээр:

3.3.1 Нийслэлийн Засаг захиргааны байруудын цэвэрлэгээ үйлчилгээ

Нийслэлийн засаг захиргааны 5 байр, Нэгдсэн 5 салбарт байрлаж буй 81 байгууллагын 2500 гаруй ажилтан, албан хаагчадад нийт 39.176 м.кв талбайн цэвэрлэгээ, үйлчилгээг хийж гүйцэтгэсэн ба төлөвлөгөөт их цэвэрлэгээг сард 2 удаа, улирлын их цэвэрлэгээг 8 удаа, баяр ёслолын болон нийтийн их цэвэрлэгээг 6 удаа буюу 2019 оны жилийн эцсийн байдлаар төлөвлөгөөт их цэвэрлэгээг 16, улирлын их цэвэрлэгээг 30, нийтийн их цэвэрлэгээг 2 удаа тус тус хийж, төрийн байгууллагын ажилтан, албан хаагчдын ажиллах цэвэр, ая тухтай орчин нөхцөлийг бүрдүүлж ажилласан.



Зураг 56. Цэвэрлэгээ, үйлчилгээ хийж буй байдал

Тайлант хугацаанд цэвэрлэгээ, үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Тухайлбал:

- Цэвэрлэгээ, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, үйлчилгээний ажилтны өдөр тутмын ажлын гүйцэтгэл, түүнд тавих хяналтыг сайжруулах зорилгоор “Хяналтын хуудас”, “Үнэлгээний карт”-ын системийг Газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцэж, загвар болон хэрэгжүүлэх хугацааг шийдвэрлэж 2019 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлэн ажиллаж байна.

- Байгууллагын “Цэвэрлэгээ, үйлчилгээний ерөнхий шаардлага”, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ерөнхий шаардлага”-ыг НЗЗ-ны 5-н байр, НҮНТ-ийн 4-н салбарын үйлчилгээний ажилтнуудын үйл ажиллагаанд нэвтрүүлэх, хэрэгжүүлж хэвшүүлэх зорилгоор байр хариуцсан менежерүүд болон үйлчилгээний ажилтнууд хамтран үзүүлэх сургалтыг 2019 оны 05 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулласан.



Зураг 57. Стандартыг хэрэгжүүлэхтэй холбоотой онолын болон үзүүлэх сургалтын үеэр

- Ажилтан, албан хаагчдын ажлын ур чадварыг дээшлүүлж, цэвэрлэгээ, үйлчилгээний чанарыг нэмэгдүүлэх зорилгоор НЗЗ-ны байрууд, НҮНТ-ийн салбаруудын ажилтнуудыг ажлын туршлага солилцуулахаар цэвэрлэгээ, үйлчилгээ, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартуудыг амжилттай хэрэгжүүлж байгаа НҮНТ-ийн Мишээл салбарын үйл ажиллагаатай танилцуулж, туршлага солилц ох ажлыг 2019 оны 05 дугаар сарын 07-ны өдөр зохион байгуулсан.



Зураг 58. НҮНТ-ийн Мишээл салбарын ажилтнуудын ажлын байр болон үйл ажиллагаатай танилцаж, туршлага солилцож байгаа ажлын үеэр

Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газар нь НЗЗ-ны байрууд, НҮНТ-ийн цэвэрлэгээ үйлчилгээг хариуцан ажиллахын сацуу төрийн албан хаагчдын ажиллах ая тухтай орчин нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр байруудын гадна болон дотор талын тохижилтын ажлыг хийж гүйцэтгэж байна. Үүнээс дурьдвал:

- НЗЗ-ны 5 дугаар байрны А, Б, В корпусуудын гадна, дотор нийтийн эзэмшлийн талбайн хогийн савны өнгө үзэмжийг сайжруулж, ангилан ялгах зориулалтай 9 ширхэг хогийн савыг байршуулсан.

- НЗЗ-ны 5 дугаар байрны А корпусын 1 дүгээр давхарын 6.80м² хана чийгний улмаас үжирч муудсан байсанд засвар үйлчилгээг хийж гүйцэтгэсэн.

- НЗЗ-ны 3-р байрны 4-р давхарын 108м² талбайг будаж, өнгө үзэмжийг сэргээсэн.

- НҮНТ-ийн Дүнжингарав салбарын НГА-ны гадна талын нийтийн эзэмшлийн талбай болох 4,5м² ханыг, ЦЕГ болон бичиг хэргийн лангууны ойр орчмын 30м² ханыг тус тус будаж, засвар үйлчилгээг хийсэн.

- НЗЗ-ны байруудын гадна талбайд ногоон байгууламжийг нэмэгдүүлж орчны тохижилыг сайжруулах зорилгоор 5 дугаар байрны А, Б, В корпусын гадна талбайд 5 төрлийн цэцгийн үр үрсэлгээ, 6 төрлийн цэцгийн мандал, НЗДТГ-ын байранд бш, НЗЗ-ны 5 дугаар байрны Улаанбаатар чуулгын цайны газарт 5ш, Хангарди ордны зоогийн газарт 11, гадна талбайд 10 төрлийн цэцгийн үрсэлгээг суулгасан.



*Зураг 59. Ногоон байгууламж, гадна тохижилтоор хийгдсэн ажлуудаас
Зураг 60. Гадна талбайн тохижилтын ажил хийгдэж буй байдал*

НЗЗ-ны 2, 3, 4, 5-р байрны А, Б, В корпусын нийтийн эзэмшлийн талбай, НЗЗ-ны 1, 2, 5А байрны зоогийн газрын нийт 14254 м² талбайд ажил гүйцэтгэх гэрээний дагуу “Улаанбаатар ариутгал” ХХК-тай хамтран ариутгал халдваргүйжүүлэлтийг хуваарийн дагуу тогтмол хийлгэж ажиллалаа.



Зураг 61. Ариутгал, халдваргүйжүүлэлтийн үеэр

3.3.2 Хоол, цай, зоогийн үйлчилгээний чиглэлээр:

Хангарди ордны зоогийн газар, НЗДТГ, Улаанбаатар чуулгын цайны газруудаар нийтийн хоол, хүндэтгэлийн хүлээн авалт, цай завсарлага, катеринг үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд үзүүлэн ажиллаж байна.

Эрүүл чанартай хоол хүнс бэлтгэх, хүнсний бараа материалыг гэрээний дагуу худалдан авахдаа эрүүл ахуйн аюулгүй байдлыг хангах зорилгоор хүнсний бүтээгдэхүүний гарал үүслийн бичиг, шинжилгээний бичгийн хамт хүлээн авдаг ба хадгалалтын горимд “Хоолны газрын нийтлэг журам”-ыг мөрдөн ажиллаж, зоогийн газар, цайны газруудын ажилтнуудыг ХУД-н Эрүүл мэндийн төв, ЧД-ийн Эрүүл мэндийн төвүүдтэй хамтран эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд тогтмол хамруулан хоол хүнсний эрүүл ахуйг хнгаж ажилласан. Мөн ЧД-ийн МХХ-т хүсэлт гарган НЗЗ-ны 1, 2, 5 дугаар байрнуудын зоогийн газруудын ундны усны шинжилгээг өгч, шинжилгээгээр ундны усны хэрэглээг бүрэн хангасан дүгнэлт гарсан.

Байгууллагын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Нийслэл хот үүсгэн байгуулагдсаны 380 жилийн ойг угтан нийслэлээс зохион байгуулагдаж буй хүндэтгэлийн хүлээн авалтын арга хэмжээнүүдэд хэрэглэгдэх, нийслэлийн өнгө төрхийг илэрхийлсэн лого бүхий шаазан эдлэл “Брэнд Бүүк”-ыг нийслэлийн хэмжээнд зохион байгуулагдаж байгаа хүндэтгэлийн хүлээн авалтын үйлчилгээндээ шинээр нэвтрүүлсэн.



Зураг 62. Нийслэлийн лого бүхий хүлээн авалтын шаазан эдлэлүүд

Нийтийн хоол:

Хангарди ордоны зоогийн газар дунджаар 52,800, НЗДТГ-ын цайны газар дунджаар 42,240, НЗЗ-ны 5-р байрны цайны газар дунджаар 39,600, Өглөөний цайг дундажаар 3800 орчим хүнд нийтийн хоолны үйлчилгээг тус тус үзүүлэн ажиллалаа.

Өдөр тутмын хоолны цэсийг улирлын онцлогт тохируулан шинэчлэн, Хангарди ордны зоогийн газрын хоолны цэсэнд нэгдүгээр хоолны 5, хоёрдугаар хоолны 10, зууш салатны 6, ЗДТГ-ын цайны сувилалын хоолны цэсийг тус тус шинэчлэн батлуулж, 2019 оны 05 дугаар сарын 06-ны өдрөөс үйлчилгээндээ нэвтрүүлэн ажиллаж байна.

Нэг удаагийн нийлэг хальсан уутыг хориглох тухай ЗГ-ын 189 дугаар тогтоол хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан савласан хоолны баглаа боодлыг цаасан уутаар шинэчилсэн.

Хүлээн авалт:

Тайлант хугацаанд хүндэтгэлийн 96 удаагийн хүлээн авалтаар 5496 хүнд, 13 удаагийн катерингийн үйлчилгээний үеэр 4115 хүнд, 8 удаагийн VIP үйлчилгээ 560 хүнд, 41 удаагийн хурлын цайны завсарлагаагаар 6189 хүнд тус тус үйлчилгээ үзүүлж ажилласан байна.

Зоогийн үйлчилгээг өмнөх онуудын мөн үетэй харьцуулахад зоогийн үйлчилгээний хүртээмж 49.7 хувиар нэмэгдэж, орлогын төвлөрөлт 58.8 хувиар өссөн байна.




График 14. Зоогийн үйлчилгээний хүртээмжийг өмнөх оны мөн үетэй харьцуулае

“Улаанбаатар марафон 2019” олон улсын гүйлтийн тэмцээний үеэр нээлтийн арга хэмжээнд оролцсон Нийслэлийн удирдлагууд болон гадны зочид төлөөлөгчид, тамирчдад VIP болон цай завсарлагын үйлчилгээг үйлчилгээний өндөр түвшинд үзүүлж ажиллалаа.



Зураг 63. Олон улсын гүйлтийн тэмцээний үеэр VIP болон цай завсарлагаа

Тулгар төр байгуулагдсаны 2228, Их Монгол улс байгуулагдсаны 813 жил Ардын хувьсгалын 98 жилийн ой, Үндэсний их баяр наадмын арга хэмжээний хүрээнд Хүй 7 худаг, Төв цэнгэлдэх хүрээлэнд 300 гаруй зочид, төлөөлөгчдөд хүндэтгэлийн зоог барьж, хүлээн авалтын үйлчилгээг чанарын өндөр түвшинд зохион байгуулан ажилласан.





Зураг 64. Үндэсний их баяр наадмын үйлчилгээний үеэр

Монгол Улсын нийслэл үүсэн байгуулагдсаны түүхт 380 жилийн ойг тохиолдуулан Нийслэлийн удирдлагууд нийслэлийн анхны шавыг тавьсан газар Гэрэлт хөшөөнд хүндэтгэл үзүүллээ. Уг арга хэмжээний үеэр Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын 50 гаруй хүний бүрэлдхүүнтэй баг хамт олон нийслэл, орон нутгийн удирдлагууд болон хүрэлцэн ирсэн зочид, нутгийн иргэдэд хүндэтгэлийн болон хээрийн хүлээн авалтын үйлчилгээг амжилттай зохион байгуулан ажилласан.



Зураг 65. Гэрэлт хөшөөний үйл ажиллагаанаас

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Амарсайханы санаачилгаар 2019 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр “Нэг хот-Нэг стандарт” нийслэлийн анхдугаар зөвлөгөөн Соёлын төв өргөөнд зохион байгуулагдаж зөвлөгөөнд оролцсон 2100 ажилтан, албан хаагчдад өглөөний цайны үйлчилгээг амжилттай үзүүлсэн.



Зураг 66. Нэг хот-Нэг стандарт анхдугаар зөвлөгөөний өглөөний цайны үйлчилгээ

Нийслэлийн Засаг даргын Хүний хөгжил, нийгмийн бодлогын асуудал хариуцсан орлогч Нийслэл дэх жендэрийн салбар хорооны дарга Ш.Анхмаагийн санаачилгаар 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдөр “Жендэр ба хөгжил” нийслэлийн анхдугаар чуулган зохион байгуулагдаж, чуулганд оролцсон нийт 1000 гаруй ажилтан, албан хаагчдад өглөөний цайны үйлчилгээг үзүүлсэн.



Зураг 67. Жендэр ба хөгжил анхдугаар чуулганы өглөөний цайны үйлчилгээ

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

Байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөх ЗГ-ын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой бодлого, шийдвэр, бусад цаг үеийн шинжтэй хийгдсэн ажлуудын талаархи мэдээ, мэдээллийг тухай бүр нь байгууллагын цахим хуудаст /www.khangardi.mn/ нээлттэйгээр байршуулж ажилласан. Тайлант хугацаанд сайтад газрын шуурхай зөвлөгөөн болон бусад үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээлэл 75, дүрэм, журам, стандарт 6-г шинээр байршуулж ажилласан байна.

НЗДТГ-ын ХШҮ-ний хэлтсээс Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын цахим хуудсын мэдээлэлд Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхий тухай хууль, Засгийн газрын 2013 оны 411 дүгээр тогтоол, 2009 оны 143 дугаар тогтоолд заасны дагуу 22 шалгуур үзүүлэлтээр үнэлгээ

хийсэн. Тус үнэлгээнд Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газар 3 байрт үнэлэгдсэн байна.

ЗГ-ын 2017 оны 89 дүгээр тогтоолын 11 дүгээр хавсралт

№	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
Нэг. Үйл ажиллагааны ил тод байдал			
1.	Эрхэм зорилго, түүний хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүн, зохион байгуулалтын бүтцийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа байрлуулан, тухай бүр шинэчлэх	Байгууллагын эрхэм зорилго, зорилт болон тэдгээрийн хүрээнд газрын зүгээс авч хэрэгжүүлсэн арга хэмжээ болон дотоод үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг үндсэн 4 чиглэлээр тухай бүр нь байгууллагын мэдээллийн самбар болон цахим хуудас www.khangardi.mn -д нээлттэйгээр мэдээллэн ажиллаж байна. Тус сайт 2019 онд 3377 хандалттай байна.	100%
2.	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа байршуулан, тухай бүр шинэчилсэн байдал	Байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөж буй дүрэм журам, стандарт, дээд газраас ирсэн тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн байдал, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн талаар мэдээ, мэдээллийг тухай бүр нь байгууллагын мэдээллийн самбар болон цахим хуудас www.khangardi.mn -д байршуулан ажилласан.	100%
3.	Үзүүлж байгаа үйлчилгээний арга, хэлбэрийг боловсронгуй болгох зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх	ННҮГ нь НЗЗ-ны байруудын цэвэрлэгээ, үйлчилгээ, инженерийн шугам сүлжээний хэвийн, найдвартай ажиллагааг хангах, эрүүл ахуйд нийцсэн зоогийн чиглэлээр үзүүлж байгаа үйлчилгээг боловсронгуй болгох зорилгоор хүний нөөцийг чадавхжуулах сургалтуудыг үе шаттайгаар зохион байгуулж ажилласан. Тайлант хугацаанд нийт 25 сургалтыг зохион байгуулсан. Мөн ННҮГ-ын үндсэн 7 чиг үүргийн хэрэгжилтэд хэрэглэгчдийн үнэлгээг тогтоох зорилгоор сэтгэл ханамжийн судалгааг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан хаагчдаас цахимаар буюу дотоод удирдлагын систем /ERP/-ээр авсан. Энэ нь цаасан хэрэглээ болон цаг хугацааг хэмнэсэн шинэлэг ажил болсон.	100%
Хэсгийн дундаж хувь:			100%

Хоёр. Хүний нөөцийн ил тод байдал			
1.	Сул орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байршуулан тухай бүр шинэчлэх, энэ тухай олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах	Хүний нөөцийн ил тод байдлыг хангах чиглэлээр ажлын байрны сул орон тоог байгууллагын цахим www.khangardi.mn сайт болон зарын нэгдсэн www.unequi.mn , www.biznetwork.mn цахим хуудас, байгууллагын мэдээллийн ил тод байдлын самбарт тухай бүр байршуулж нийтэд мэдээллэхийн зэрэгцээ ажлын байрны захиалга, зарыг нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газарт болон дүүргүүдийн Хөдөлмөр халамж, үйлчилгээний хэлтэст сард 2 удаа хүргүүлэн ажилласан. 2019 оны эхний жилийн эцсийн байдлаар дээрх хөдөлмөр зуучлалын мэдэгдэл, зараар ирсэн нийт 75 иргэний материалуудаас сонгон шалгаруулт хийж 50 хүн шинээр ажилд орсон байна	100%
2.	Албан хаагчийн ёс зүйн дүрмийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх	ННҮГ-ын даргын 2019 оны А/20 дугаар тушаалаар баталсан “Байгууллагын ёс зүйн дүрэм”, байгууллагын “Ёс зүйн зөвлөлийн ажиллах журам”-ыг байгууллагын цахим хуудас /www.khangardi.mn/ -д байршуулан, газрын даргын шуурхай зөвлөгөөнөөр захиргааны 44 албан хаагчдад танилцуулж, өөрсдийн хариуцсан байруудын үйлчилгээ, техникийн ажилтнуудад танилцуулж, мөрдлөг болгон ажиллахыг байр хариуцсан менежерүүдэд үүрэг болгон ажилласан.	100%
3.	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээллэж байх	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр байгууллагын цахим хуудас www.khangardi.mn -д хөдөлмөрийн харилцаатай холбоотой эрх зүйн акт, ажлын байрны сул орон тоотой холбоотой зар, ажилтан, албан хаагчдыг чадавхжуулах зорилгоор зохион байгуулсан сургалтууд, шинээр ажилд орсон албан хаагчдын талаар мэдээ, мэдээллийг байгууллагын цахим хуудсын хүний нөөцийн ил тод байдлын хэсэгт тухай бүр шинэчлэн байршуулж ажилласан.	100%
4.	Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга	Байгууллагын хэлтэс, албадын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн ажлын мэдээ, ажилтан, албан хаагчдын ажлын цаг ашиглалт болон ажлын ур чадвар дүгнэсэн мэдээ, ННҮГ-аас үзүүлж буй үйлчилгээнд хэрэглэгчдээс өгсөн сэтгэл ханамжийн судалгааны дүн зэрэг мэдээ, мэдээллийг байгууллагын мэдээллийн самбар, цахим хуудас /www.khangardi.mn/	

хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээллэж байх	хуудаст тухай бүр байршуулан ажилласан.	100%
Хэсгийн дундаж хувь:		100%
Хэрэгжилтийн дундаж хувь:		100%

ТАВДУГААР БҮЛЭГ. БУСАД ЦАГ ҮЕИЙН АЖЛЫН ХЭРЭГЖИЛТ

Олон улсын эмэгтэйчүүдийн баярыг угтан “Их хотын бүсгүйчүүд-2019” хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгуулахтай холбогдуулан “Нэг зүрх-нэг Нийслэл” аяныг 02 дугаар сарын 27-03 сарын 04-ний өдрүүдэд зохион байгуулж тус аяны хүрээнд байгууллагын хэмжээнд ажиллаж буй Алдарт эхийн одонтой 25 ээж, зорилтод бүлгийн 32 эмэгтэй ажилтан, албан хаагчдыг хүлээн авч хүндэтгэл үзүүлсэн ба энэхүү арга хэмжээний үеэр эмэгтэй ажилтан, албан хаагчдын дунд “Би Монгол эмэгтэй” шүлгийн уралдаан зарлан явуулж, нийт 35 шүлэг ирснээс НЗЗ-ны 1-р байрны Н.Энхмаа, НЗЗ-ны 2-р байрны Х.Ундармаа, НҮНТөв Мишээл салбарын ажилтан Ц.Цэцэгмаа нарын шүлэг эхний 3 байрт шалгарч, шүлгийн эздийг дурсамж бичиг, гарын бэлгийн хамт шагнаж урамшуулсан.

Мөн Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрт ажиллаж буй ТҮК-ийн 20 эмэгтэй ажилтанд 05 цагт өглөөний цайгаар үйлчилж сэтгэлийн бэлэг барьсан.



Зураг 68. Их хотын бүсгүйчүүд арга хэмжээний үеэр

Бүх нийтийн их цэвэрлэгээ зохион байгуулах тухай Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн тушаалын дагуу Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас 2019 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр “Их хотын их цэвэрлэгээний 90 минут” бүх нийтийн хаврын их цэвэрлэгээнд Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын 227 ажилтан, албан хаагч Туул голын эрэг орчмын хуваарьт 1600м газрын хог хаягдлыг цэвэрлэж, 273 шуудай хогийг түүж цэвэрлэн нийслэл хотынхоо өнгө үзэмж, цэвэр, эрүүл орчин бүрдүүлэх арга хэмжээнд идэвхтэй оролцсон.



Зураг 69. Туул голын эрэг орчмын их цэвэрлэгээний үеэр

Төр Засгийн үйлчилгээ эрхлэх газартай хамтран үйлчилгээний ажилтны мэргэжлийн үнэмлэх, зэрэг олгох онол, практикын сургалтад хамрагдсан 20 ажилтанд 2019 оны 05 сарын 02-ны өдөр мэргэжлийн үнэмлэхийг олгох арга хэмжээг амжилттай зохион байгууллаа.



Зураг 70. Үйлчилгээний ажилтны мэргэжлийн үнэмлэх, зэрэг олгох арга хэмжээний үеэр

Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг угтан байгууллагын эцэг, эхийн зөвлөлөөс байгууллагын ажилтан, албан хаагчдын хүүхдүүдийн дунд “Хүүхэд бүхэн инээж байг” арга хэмжээг зохион байгуулан 48 хүүхдийн 68 бүтээлээр “Би зурах дуртай” гар зургийн үзэсгэлэн гаргасан ба үзэсгэлэнд идэвхтэй оролцсон 48 хүүхэд мөн 2018-2019 оны хичээлийн жилд сурлага, урлаг, спортоор амжилт үзүүлсэн шилдэг 20 бяцхан авъяастнуудад талархал илэрхийлэн Монголын хүүхдийн ордны сурагчдын нэгдсэн тоглолтын тасалбарын хамт гарын бэлэг гардуулж урамшуулсан.



Зураг 71 . “Би зурах дуртай” сэдэвт гар зургийн үзэсгэлэн

Улаанбаатар хотын ерөнхий менежерийн 2019 оны А/143 дугаар тушаалын дагуу хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилан ялгах, багасгах, бууруулах, дахин ашиглах талаар иргэдийн мэдлэг, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Өөрт хэрэггүй зүйлээ хэрэгтэй нэгэндээ өгцгөөе” уриатай хуучин эд зүйлээ худалдах, солилцох, үнэгүй өгөх “Өгөөмөр өдөр” өдөрлөгийг зохион байгуулж ажилтан, албан хаагчид идэвхтэй хамрагдсан.



Зураг 72. “Өгөөмөр өдөр” өдөрлөгийн үеэр

ННҮГ-аас үзүүлж буй цэвэрлэгээ, үйлчилгээ, зоогийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд гарах шинэ санал, санаачилгыг дэмжин, идэвхжүүлэх зорилгоор НЗЗ-ны байрууд болон НҮНТ-ийн салбаруудад ажиллаж байгаа үйлчилгээ, техникийн ажилтнуудын дунд “Соёлтой үйлчилгээ-Бүтээлч санаа” сэдэвт болзолт уралдааныг 2019 оны 05 дугаар сарын 13-наас 06 дугаар сарын 13-ны өдрийг хүртэл 1 сарын хугацаатай зохион байгуулсан ба уралдаанд НЗЗ-ны 5-н байр, НҮНТ-ийн 3-н салбарын 14 баг оролцсон.

Тус болзолт уралдаанд НЗЗ-ны 5А байр 1, НҮНТ-ийн Дүнжингарав салбар 2, НЗЗ-ны 5В байр 3, НЗЗ-ны 2 дугаар байрны БАА-ны баг болон НҮНТ-ийн Драгон салбарын баг тусгай байрыг тус тус эзэлсэн.

Болзолт уралдааны хүрээнд хийгдсэн ажлуудаас түүвэрлэн зургаар үзүүлвэл:



Зураг 73. НҮНТ Дүнжингарав салбар, Хүүхэд саатуулах өрөөг тохижуулсан



Зураг 74. НЗЗ-ны 5А байр, замын хайс хийсэн



Зураг 75. НЗЗ-ны 2-р байр хоёрдогч түүхий эдээр хийсэн сандал



Зураг 76. НЗЗ-ны 2-р байр Угтах үйлчилгээний хаягийг шинэчлэсэн



Зураг 77. НЗЗ-ны 5В байр хаягдал төмрөөр цэвэрлэгээний материал зөөвөрлөх тэрэг



Зураг 78. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан гарц

Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/920 дугаар захирамжийн хэрэгжилт, иргэдийн аюулгүй цэвэр орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор “Цэвэр агаартай автомашингүй өдөр” арга хэмжээний хүрээг тохиолдуулан 2019 оны 09 дүгээр сарын 14-ний өдөр зохион байгуулагдсан намрын их цэвэрлэгээнд 173

ажилтан, албан хаагчид хамрагдаж Туул голын эрэг орчим 1600м газарт цэвэрлэгээ хийж 181 шуудай хогийг түүж цэвэрлэсэн.



Зураг 79. Намрын их цэвэрлээний үеэр

Нийслэл Улаанбаатар хот үүсэн байгуулагдсаны 380 жилийн ойн баярын өдөр буюу 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдөр Нийслэлийн засаг захиргааны 5-н байр, Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн 4-н салбарт ажиллаж буй Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд болон төрийн албан хаагчид, иргэдэд Нийслэлийн өдрийн баярын мэнд дэвшүүлж угтан авах үйлчилгээг баяр ёслолын байдалтайгаар зохион байгуулж ажиллалаа.



Зураг 80. Нийслэлийн 380н жилийн ойн баярын мэндчилгээг хүргэн угтан авч байна

Монгол Улсын Засгийн газрын “Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай” 2018 оны 62 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2019 оны “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” А/1016 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд захиргаа санхүүгийн хэлтсийн албан хаагчид өндөржүүлсэн бэлэн байдлаар Сонгинохайрхан дүүргийн 4, 26, 36 дугаар хороодын борлуулалтын цэгүүдэд сайжруулсан түлшний түгээлт, нийлүүлэлтэд хяналт тавин, зөв хэрэглэх заавар зөвлөмжийг 2 удаа тарааж тухай бүр мэдээг нэгтгэн дээд байгууллагад хүргүүлж ажилласан.

Сайжруулсан түлшний нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор “Таван толгой түлш” ХХК-ийн түлш шуудайлах сайн дурын ажилд Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газар нь 2019 оны 11 сараас 2020 оны 04 дүгээр сар хүртэлх хугацаанд ажиллах хуваарь гарган хуваарийн дагуу ажиллаж байгаа бөгөөд 2019 оны 12 дугаар сарын 16-ны өдрөөс сайжруулсан түлш борлуулах цэгүүдэд картаар үйлчлэх байдал, нөөцөд 24 цагийн хяналт тавин ажиллах хуваарь гарган хуваарийн дагуу өдөрт 2 удаа мэдээг холбогдох газар хүргэж ажиллаж байна.



Зураг 81. Зөвлөмж тараах болон түлш шуудайлж буй үе

ЗУРГАА. ДҮГНЭЛТ

Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газар нь Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2019 оны “Иргэдийн оролцоотой-Хөгжлийн жил”-ийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан үйл ажиллагааны хэрэгжилтийг ханган ажилласан бөгөөд нутгийн захиргааны байгууллага болон төрийн албан хаагчдад үзүүлэх төрийн үйлчилгээний чанар стандартад нийцсэн нийтлэг үйлчилгээг үзүүлж, үр дүнг тооцож ажилласан.

Тайлант хугацаанд холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, захирамж, албан даалгаврын хүрээнд хамааралтай заалт, дүрмээр хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтийг ханган, олон шинэлэг ажлуудыг хэрэгжүүлж, байгууллагын ил тод байдал, төсөв санхүүгийн сахилга батыг ханган ажиллалаа.

Нийтлэг үйлчилгээний газар нь ажилтан, албан хаагчдынхаа нийгмийн асуудал, сурч боловсрох, тэдний ажиллах нөхцөл боломжийг сайжруулахад анхааран, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд нийцүүлэн ажиллаж, хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээ, үйл ажиллагаагаа бүрэн хангалттай хэрэгжүүлж ажилласан. Тухайлбал:

- Байгууллагын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Нийслэл хот үүсгэн байгуулагдсаны 380 жилийн ойг угтан нийслэлээс зохион байгуулагдаж буй хүндэтгэлийн хүлээн авалтын арга хэмжээнүүдэд хэрэглэгдэх, нийслэлийн өнгө төрхийг илэрхийлсэн лого бүхий шаазан эдлэл “Брэнд Бүүк”-ыг нийслэлийн хэмжээнд зохион байгуулагдаж байгаа хүндэтгэлийн хүлээн авалтын үйлчилгээндээ шинээр нэвтрүүлээ.
- Санал асуулга, судалгаа явуулахад цаасан хэрэглээг багасгах, цаг хугацааг хэмнэх зорилгоор ERP систем буюу цахим хэлбэрээр судалгаа авах ажлыг Мэдээлэл, технологийн газар, “Ухаалаг шийдэл” ХХК-тай хамтран шинээр нэвтрүүлж, тайлант хугацаанд нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын хүрээнд 2 удаа судалгаа авч дүнг нэгтгэн ажилласан.
- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 150 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий сайдын 2019 оны 46 дугаар захирамж, Хууль зүй, дотоод хэргийн сайдын баталсан улсын үзлэг явуулах хуваарийн дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Нандинжаргалаар ахлуулсан ажлын хэсэг “Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг”-ийг 2019 оны 09 дүгээр сарын 23-25-ны өдрүүдэд Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газарт зохион байгуулсан. Тус үзлэгийн нэгдсэн дүнгээр манай байгууллага 94 хувь А буюу “Бүрэн хангалттай” үнэлэгдэж дүгнэгдсэн байна.
- НЗДТГ-ын ХШҮ-ний хэлтсээс Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын цахим хуудсын мэдээлэлд Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхий тухай хууль, Засгийн газрын 2013 оны 411 дүгээр тогтоол, 2009 оны 143 дугаар тогтоолд заасны дагуу 22 шалгуур үзүүлэлтээр үнэлгээ хийсэн. Тус үнэлгээнд Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газар 3 байрт үнэлэгдсэн байна.
- Нийслэлийн Засаг даргын тамгын газраас нийслэлийн харъяа байгууллагуудын дунд хамт олны эрүүл амьдрах хандлага, зан үйлийг төлөвшүүлэх, ажилчдын эрүүл мэндийг дэмжих орчинг бий болгох зорилгоор сүүлийн 3 дахь жилдээ “Эрүүл ажлын байр” удирдамжийг хэрэгжүүлж байгаа бөгөөд Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газар олон бүтээлч ажлыг санаачлан, хэрэгжүүлж ажилласанаар 2019 оны 12 дугаар сарын 20-ны

өдөр “Эрүүл ажлын байр” бүрдүүлсэн байгууллагаар хоёрдугаар байрт шалгарч 2018, 2019 оны хошой 2 дугаар байрны эзэн болсон.

ТАНИЛЦСАН:

ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Х.ЭРДЭНЭБИЛЭГ

ХЯНАСАН:

ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Ч.ШИНЭЧИМЭГ

ТАЙЛАН БИЧСЭН:

ДОТООД АЖИЛ, СУРГАЛТ
ХАРИУЦСАН АЖИЛТАН

Ц.ҮРЭЛМАА